



World Vision



ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

(Судалгааны тайлан)



АГУУЛГА

Нэг.	УДИРТГАЛ	5
Хоёр.	ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮНДСЭН АСУУДАЛ	7
	2.1. Олон улсын гэрээ, конвенц, бусад эх сурвалж	7
	2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үндсэн асуудлууд	11
	2.3. Хохирогчийн нэр төрийг хамгаалах, хувийн нууцлалыг хадгалах	21
	2.4. Насанд хүрээгүй хохирогчийн онцлог	23
	2.5. Бусад асуудал	25
Гурав.	ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА	27
	3.1. Испани	27
	3.2. Тайвань	31
	3.3. Босни-Герцоговени	35
Дөрөв.	ДҮГНЭЛТ, САНАЛ	40

2020 оны 04 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар болон Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хооронд “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-г байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төсөл дөрвөн жилийн хугацаанд хэрэгжиж байгаа бөгөөд Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллага болон Азийн сан хамтран хэрэгжүүлж байна. Төслийн үйл ажиллагааг ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба болон ХНХЯ ерөнхий удирдлагаар ханган ажиллаж байна.

Энэхүү судалгааны тайланг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн 5.2.3-т заасан Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмыг боловсруулахад ашиглах зорилгоор Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн Ажлын албаны захиалгаар төслийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Судалгааг хийж гүйцэтгэсэн Судлаач С.Билгүүн (LL.M)

мэдэгдэл

Энэхүү судалгааг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

1 | УДИРТГАЛ

Хүн худалдаалах нь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчлийн нэгэнд зүй ёсоор тооцогдож байна. Уг гэмт хэрэг нь хүнийг ашгийн төлөө урьдаас зохион байгуулалттайгаар өөр газарт шилжүүлж,¹ төрөл бүрийн мөлжлөгт оруулдгаас гадна хүч хэрэглэх, хууран мэхлэх, айлгах, дарамтлах зэрэг олон арга хэрэглэдэг тул энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж, мөрдөн шалгах, буруутай этгээдийг яллаж, хуулийн хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулдаг.² Түүнчлэн уг гэмт хэрэг авлига, хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах, боолчлох, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, хүнийг хүчээр гэрлүүлэх зэрэг олон төрлийн гэмт хэрэгтэй хавсардгаас гадна улс орны дотоодод төдийгүй хил дамнан үйлдэгддэг онцлогтой тул илрүүлэхэд хүндрэл бэрхшээл учирдаг.

Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тогтмол хүчин чармайлт гаргаж ирсэн. Улсын Их Хурлаас Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (цаашид “Нэмэлт протокол” гэх)-ыг 2008 оны 06 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын өмнө үүрэг хүлээсэн. Мөн Улсын Их Хурлаас 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг батлан гаргасан бөгөөд нийтдээ 18 зүйлтэй тус хуульд хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны үндсэн зарчим, үйл ажиллагааны зохион байгуулалт, уг үйл ажиллагааны арга хэлбэр (хамгаалах байр, хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ, хохирогч хүүхдийг хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх, уг үйл ажиллагааны санхүүжилт), хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг асуудлыг тусгасан байна.

¹ Хүн худалдаалах гэмт хэрэгт хохирогчийн байршлыг шилжүүлсэн байхыг шаардахгүй болно

² UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking (20я08), Guideline 2, page 4.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан бөгөөд тус хөтөлбөр 2021 онд хэрэгжиж дууссан байна. Тус хөтөлбөрийн 3.2-т хохирогч хамгааллын чиглэлийн үйл ажиллагаа зарим талаар хангалтгүй байгаа талаар дурдаад энэ төрлийн хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилтыг тавьж, тодорхой ажил хийгджээ.

Гэвч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын өнөөгийн тогтолцоонд цөөнгүй дутагдал байна. АНУ-ын Хүн худалдаалах гэмт хэргийн тайланд дурдсанаар хохирогчийг таньж илрүүлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээнд холбон зуучлах механизм дутмаг, цар тахлын улмаас хохирогч хамгааллын үйл ажиллагаанд төсөв санхүүжилт дутагдалтай болсон, хамгаалах байрны орчин нөхцөл тааруу, хараа хяналт сул, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хохирогчоор тогтоох зохицуулалт хоорондоо зөрчилдсөн, хохирогчийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зарчим тодорхой тусгагдаагүй байна.³

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон Улсын Ерөнхий прокурор хамтран батлахаар заасан бөгөөд уг журмын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүднээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын талаарх сайн туршлагыг тусгасан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Уг судалгааны хүрээнд Нэмэлт протокол, түүнийг хэрэгжүүлэх талаар гаргасан зөвлөмж, загвар хууль, олон улсын хэмжээнд гаргасан гарын авлага, зааварчилгаа, зөвлөмж зэргээс гадна энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ахиц дэвшил гаргасан болон өөрийн улстай ижил төстэй эрх зүйн тогтолцоотой улс орнуудын туршлагыг харьцуулан судалж тодорхой зөвлөмж боловсруулсан.

Энэхүү тайлан нь хоёр хэсгээс бүрдэнэ. Эхэн хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, конвенц, баримт бичиг, судалгаа, гарын авлага зэрэгт хэрхэн тусгасан талаар буюу олон улсын нийтлэг жишиг туршлагыг, удаах хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах чиглэлээр сайн туршлага бүхий зарим улсын туршлагыг танилцуулна.

³АНУ-ын Төрийн департамент, Хүн худалдаалах гэмт хэргийн тайлан мэдээ (2022), Монгол Улс. <https://www.state.gov/reports/2022-trafficking-in-persons-report/mongolia/>

2

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ҮНДСЭН АСУУДАЛ

2.1. Олон улсын гэрээ, конвенц, бусад эх сурвалж

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хамгаалах чиглэлээр олон улсын эрх зүйн болон сургалт, судалгааны цөөнгүй эх сурвалж нийтлэгджээ.

а. Олон улсын гэрээ, конвенц

Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаа олон улсын түвшинд тууштай явагдаж ирсэн. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 6 дугаар зүйлд гишүүн улсууд нь дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүргийг хүлээлгэжээ:

- Дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, хувийн нууцлалыг нь хамгаалах арга хэмжээ авах;⁴
- Хохирогчид шүүхийн болон захиргааны процессын шинжтэй мэдээллийг өгөх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгдэгчийн эсрэг үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход нь туслалцаа үзүүлэх;⁵

⁴ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 6.1 дэх заалт. <https://www.unodc.org/res/human-trafficking/2021the-protocol-tip.html/TIP.pdf>.

⁵ Мөн тэнд, 6.2 дахь заалт.

- Иргэний нийгмийн хэсэг, төрийн бус байгууллагуудтай хамтран хохирогчийг орон байраар хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд материалын тусламж үзүүлэх, хөдөлмөр эрхлэх, боловсрох, сургалтад хамрагдахад нь туслалцаа үзүүлэх;⁶
- Өөрийн нутаг дэвсгэрт хохирогчийн бие махбодын аюулгүй байдлыг хангах⁷ зэрэг болно.

б. Хүн худалдаалахтай тэмцэх тухай загвар хууль

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын түвшинд гаргаж буй хүчин чармайлт дотроос НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (United Nations Office on Drug and Crime), Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (International Organization for Migration) зэрэг байгууллага чухал байр суурь эзэлдэг. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гишүүн улсуудад Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод нэгдэн орох, түүний нэмэлт протоколыг батлах, улмаар тус конвенцын хэрэгжилтийг өөрийн нутаг дэвсгэрт хангуулах явдлыг гишүүн улсуудын хэмжээнд дэлгэрүүлэх, дэмжлэг үзүүлэх талаар гаргасан хүсэлтийн дагуу Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас Хүн худалдаалахын эсрэг загвар хууль⁸ (англ. The UNODC Model Law against Trafficking in Persons)-ийг 2009 онд анх гаргаж байв. Ийнхүү гаргахдаа Нэмэлт протоколын холбогдох заалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аливаа улсын эрх зүйн уламжлал, нийгэм, эдийн засаг, соёл, газарзүйн онцлогт нийцэх байдлаар боловсруулсан байна. Мөн загвар хуулийг хэрхэн ойлгох, үндэсний эрх зүйн тогтолцоонд хэрхэн тохируулж оруулах талаар тусгайлсан тайлбар оруулж өгсөн байдаг.

Мөн тус байгууллагаас 2020 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн загвар заалт (англ. The Model Legislative Provisions against Trafficking in Persons)-ыг гаргасан бөгөөд энэхүү баримт бичиг нь 2009 онд гарсан Загвар хуулийн шинэчилсэн хувилбар юм. Анхны загвар хуулийг гаргах үед Конвенцын нэмэлт протоколд нийт 135 улс нэгдсэн байсан бол 2020 оны сүүл гэхэд 178 улс нэгдэн орсон байсан ба энэ хэрээр Конвенцыг нэгдмэл байдлаар ойлгож хэрэгжүүлэх явдлыг түгээн дэлгэрүүлэх, хүн худалдаалахтай тэмцэх талаар олон улс, бүс нутагт гарч буй ахиц дэвшлийг сурталчлан таниулах зорилгоор уг хувилбарыг боловсруулжээ.⁹

⁶ Мөн тэнд, 6.3 дахь заалт.

⁷ Мөн тэнд, 6.5, 6.6 дахь заалт.

⁸ Загвар хуулийг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын албан ёсны цахим хуудасны дараах холбоосоор орж үзнэ үү. https://www.unodc.org/e4j/data/_university_uni_/model_law_against_trafficking_in_persons.html

⁹ UNODC, The Model Legislative Provisions against Trafficking in Persons, (Vienna: 2020), p.9.

в. Зөвлөмж, гарын авлага, судалгаа

Хүн худалдаалахтай тэмцэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр олон улсын хүчин чармайлтыг нэгтгэх, тулгамдаж буй асуудлыг ижил өнцгөөс харж шийдвэрлэх, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар олон улсын байгууллагуудаас багагүй хүчин чармайлт гаргасны дүнд суурь шинжтэй зөвлөмж, гарын авлага, судалгааны материал цөөнгүй бий болжээ. Жишээ нь НҮБ-ын Хүний эрхийн комиссарын газраас 2008 онд **Хүний эрх ба хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зарчим, удирдамжийг** гаргасан¹⁰ бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хүний эрхэд суурилсан, практикт түшиглэсэн зөвлөмж, зааварчилгааг тусгажээ. Мөн онд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас Нэмэлт протоколын зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, бодлого тодорхойлогч, хууль сахиулагч, шүүгч, прокурор, хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэгч нар, иргэний нийгмийн байгууллагуудад зориулан 2008 онд **Хүн худалдаалахтай тэмцэх гарын авлагыг** гаргажээ.¹¹ Уг гарын авлагад хүн худалдаалахтай тэмцэх талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээ, үндэсний хэмжээний стратеги, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах аргачлал, олон улсын хамтын ажиллагаа (эрх зүйн харилцан туслалцаа, хамтын ажиллагаа г.м), хууль сахиулах, мөрдөн шалгах, яллах ажиллагаа, хохирогчийг таньж тогтоох ажиллагаа, хохирогчийн оршин суух зөвшөөрөл, түүнийг сунгах, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөтөлбөрийн үнэлгээ, мониторингийн асуудлуудыг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, улс орнуудын сайн туршлага, нийтлэг жишигт тулгуурлан тусгажээ.

Мөн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас **“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах үндэсний лавлагаа механизм”** гарын авлагыг 2004 онд гаргасан байна.¹² Тус гарын авлагад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, түүнд үйлчилгээ үзүүлэх талаарх цогц асуудлуудыг тусгажээ.

Түүнчлэн хүн худалдаалахтай тэмцэх арга хэмжээний тухай Европын зөвлөлийн конвенцын дагуу уг конвенцын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй **Европын зөвлөлийн Хүн худалдаалахтай тэмцэх арга хэмжээний экспертийн бүлгийн тайланд**¹³ Европын улс орнуудын хүн худалдаалахтай тэмцэх талаар гаргаж байгаа хүчин чармайлт, ахиц дэвшлийг олж харах боломжтой байна.

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

¹⁰ UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking (2008).

¹¹ UNODC, Toolkit to Combat Trafficking in Persons: Global Programme against Trafficking in Human Beings (Vienna, 2008).

¹² OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004).

¹³ The Group of Experts on Action against Trafficking in Human Beings (European Council), <https://www.coe.int/en/web/anti-human-trafficking/greta>

Дээрхтэй адилаар АНУ-ын Төрийн департаментаас тус улсын гадаад улс дахь ЭСЯ, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, судалгаа, тайлан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний судалгаа зэрэгт тулгуурлан хүн худалдаалахтай тэмцэх талаар гаргаж хүчин чармайлтыг үнэлсэн Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын тайлан гаргадаг. Үнэлгээндээ үндэслэн улс орнуудыг гурван түвшин (Tier)-д ангилан авч үздэг. Нэгдүгээр түвшний хувьд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хүчин чармайлт гаргадаг, тус улсын Хүн худалдаалах болон хүчирхийллийн хохирогчийг хамгаалах тухай хууль (2000)-д шаардлагуудыг биелүүлсэн улсуудыг, хоёрдугаар түвшинд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагыг хэсэгчлэн биелүүлсэн бөгөөд бүрэн хэмжээнд хангах талаар бодитой хүчин чармайлт гарган ажиллаж байгаа улсуудыг, хоёрдугаар түвшний анхаарах шаардлагатай улсуудын хувьд дээрх шаардлагыг хэсэгчлэн хангасан боловч хүн худалдаалах гэмт хэргийн гаралт ихсэж байгаа боловч уг асуудалд анхаарал хандуулдаггүй, эсхүл тавьж буй хүчин чармайлтаа нотолж чадаагүй улсуудыг, гуравдугаар түвшний хувьд шаардлага хангаагүй бөгөөд хангалттай хүчин чармайлт гаргадаггүй улсуудыг багтаадаг.

Тайланг бэлтгэхдээ хүн худалдаалах үйлдэл, эс үйлдэхүйг хориглох, түгээмэл үйлдэгддэг хэлбэрийг идэвхтэй яллаж, шийтгэх замаар хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй хангадаг, хорих ялын хэмжээг дөрвөн жилээс багагүйгээр тогтоох, хохирогчийг таньж тогтоох идэвхтэй арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль сахиулах болон хохирогчтой тэргүүн эгнээнд холбогддог субъектүүдэд зааварчилгаа, дүрэм, журам гаргаж өгсөн, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлээр хангалттай төсөв хөрөнгө зарцуулсан, төрийн бус байгууллагатай хамтран ажилласан, хохирогчийг хамгаалах арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлсэн, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлсэн, хохирогчийн аюулгүй байдлыг хангаж хамгаалан нутаг буцаах ажиллагааг хийсэн, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, олон улсын шинжтэй бэлгийн сэдэл, зорилготой аялал жуулчлалыг бууруулах, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн зүгээс шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн зэрэг шалгуур үзүүлэлтийг удирдлага болгодог байна.¹⁴

Уг тайлангаас дэлхийн улс орнуудын хүн худалдаалахтай тэмцэх, буруутай этгээдийг яллах, хохирогчийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажил, гарсан үр дүн, практик мэдээлэл зэрэг судалгаанд нэн шаардлагатай мэдээллийг олж авах боломжтой юм.

¹⁴ АНУ-ын Төрийн департамент, Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын тайлан (2022), 55 дахь тал.

Хүний эрхийг хамгаалах, хохирогч болон үйлдэгчийг таньж тогтоох, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ, хууль тогтоомжийн зохицуулалтыг бүрдүүлэх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа, хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, хохирогч хүүхдийг хамгаалах тусгайлсан арга хэмжээ, зөрчигдсэн эрхийг сэргээх, энхийг сахиулагч, цагдаа, хүмүүнлэгийн болон дипломат төлөөлөгчийн үүрэг, олон улсын хамтын ажиллагаа зэрэг асуудлыг тусгажээ.

Энэ бүлгийн дараагийн дэд хэсэгт дээрх олон улсын эрх зүйн баримт бичиг болон судалгааны тайлан, гарын авлага, зөвлөмж зэрэгт тулгуурлан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах талаарх нийтлэг туршлагыг дэлгэрүүлэн авч үзэх болно.

2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үндсэн асуудлууд

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үйл ажиллагаа нэгдмэл бөгөөд цогц байдлаар явагдах ёстой. Ийм учир Нэмэлт протоколын “Хохирогч хамгаалал” гэсэн II бүлэгт хохирогчид үзүүлэх дэмжлэг, тусламж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, нөхөн төлбөр зэргийг хамтад нь тусгаж өгсөн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалал өөрийн гэсэн онцлогтой явагддаг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь ихэвчлэн далд орчинд нууцаар үйлдэгддэг бөгөөд түүнийг гэрчлэх цорын ганц этгээд нь хохирогч байх тохиолдол олон бий. Ийм учраас хохирогч нь гэрчийн үүрэгтэйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь бий. Энэ үүднээс нь хууль сахиулах, мөрдөх, прокурорын байгууллагын зүгээс хохирогчийг гэмт хэргийг мөрдөж нотлоход ашиглах хэрэгсэл гэж үзэн хэт улайрах, хохирогчийн онцлогийг үл хайхарсан тохиолдолд хэрэгт ач холбогдолтой мэдээллийг гаргуулж авах боломжгүй болох, мөрдөн шалгах ажиллагаа үр дүнгүй болох, мөн хохирогч сэтгэл зүй, бие махбодоороо дахин хохирох, улмаар гэмт хэрэг нуугдмал шинжтэйгээрээ үлдэж энэ төрлийн гэмт хэрэгт татагдан орох магадлалтай эмзэг бүлгийнхэн анхаарал халамжаас гадуур хоцрох зэрэг үр дагаварт хүрч мэднэ.

Иймд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах, шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлэх нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үндсэн байр суурь эзлэх ёстой.¹⁵ Тодруулбал, тухайн хүн өөрөө хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж

¹⁵ United Nations High Commissioner for Human Rights (UNHCHR) “Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking” (May 2002), Principles: Article 1.

байгаагаа мэдсэн, ойлгосон эсэхээс үл хамаараад түүнийг таньж тогтоох, хамгаалалтад авах, эрүүгийн хариуцлагад татагдахаас чөлөөлөх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үр дүнтэй, онцлогт нь тохирсон хэлбэрээр оролцуулах, мэдүүлэг тайлбар гаргуулах, өөр улсын иргэн байгаа тохиолдолд түр оршин суух зөвшөөрөл олгох, тодорхой туслалцаа үзүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалж хамгаалах, хэвийн амьдралд эргэн оруулах зэрэг бүхий л үйл ажиллагааг цогцоор нь авч үзэх хэрэгтэй болдог.

Түүнчлэн хохирогч хүүхдийн хувьд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Тухайн хүүхдийн хүйс, соёл, иргэншил, гэр бүлийн байдал зэргээс үл хамаараад хүүхэд гэдэг үүднээс онцгой анхаарч харилцах ёстой. Мөн тодорхой байдлаар бэлтгэгдэж магадлан итгэмжлэгдсэн, эсхүл хохирогч хамгааллын чиглэлээр албан ёсоор түншилж ажилладаг этгээдийг татан оролцуулж болно. Хүүхэд нь тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж буй мэргэжилтнүүд болон тэднийг хамгаалах зорилго бүхий тогтолцоонд итгэж найдах байдлыг төрүүлбэл зохино.¹⁶

Судалгааны энэ хэсэгт өмнө дурдсан олон улсын гэрээ, конвенц, загвар хууль, гарын авлага, зөвлөмж зэрэг баримт бичигт хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах талаар хэрхэн тусгасныг авч үзнэ. Эдгээр баримт бичгээс үзвэл “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хамгаалалт” (Victim Protection of Trafficking in Human Beings) гэсэн цогц ойлголт дурдагдаж байна.

Юуны өмнө хохирогч хамгаалал амжилттай явагдах суурь нөхцөл нь хохирогчийг таньж тогтоох ажиллагаа гэж хэлж болно. Зөв, шуурхай тогтоож хамгаалалтын арга хэмжээ, нийгмийн үйлчилгээнд хамруулахгүйгээр гэмт хэргийг нотлох, яллах, хохирогчийг хамгаалах боломж байхгүй. Энэ ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа албан ёсоор эхэлж, эрүүгийн хэрэг үүсгэсэн, буруутай этгээдийг яллагдагчаар татсан эсэхээс үл хамаарч хохирогч тогтоох ажиллагаа явагдаж, хамгаалалтын арга хэмжээг авах ёстой гэж олон улсад үздэг.¹⁷ Хохирогчийг таньж тогтоож чадаагүй нь тухайн хүний эрхийн зөрчил болно.¹⁸ Түүнчлэн хууль сахиулах, мөрдөх байгууллагаас гадна хохирогчтой хамгийн түрүүнд холбогддог нийгмийн үйлчилгээний чиглэлийн албан хаагчид хохирогчийг таньж тогтоох үйл явцад оролцох нь зүйтэй байдаг байна. Эдгээрт гадаадын иргэн, харьяатын албан хаагчид, хөдөлмөрийн улсын байцаагч, нийгмийн халамж, үйлчилгээний ажилтан, хүүхэд хамгааллын мэргэжилтэн,

¹⁶ OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons (2022), page 72.

¹⁷ UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 57.

¹⁸ UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking (2008), page 4.

сурган хүмүүжүүлэгч багш нар, эмнэлгийн ажилтан, дипломат болон консулын албан хаагч, таксины жолооч, бар, рестораны эзэн, зөөгч зэрэг хохирогчтой шууд харилцах боломжтой субъектүүд байж болдог байна.¹⁹

Иймд эдгээр албан хаагчдад хохирогчийг таньж тогтоох тодорхой аргачилсан заавар гаргасан байх (жишээ нь цагдаа, эмч, нийгмийн ажилтны гэх зэргээр), эдгээр нь шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд суралцсан байх хэрэгтэй.²⁰ Жишээ нь НҮБ-ын Загвар хуульд тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын хүлээх үүргийг тусгаж өгсөн байна.²¹ Үүнд 1) зорчигч нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэх, 2) зорчигч бүрд тийз, тасалбар болон тухайн улсад нэвтрэх, оршин суух зөвшөөрөл байгаа эсэхийг нягтлах, 3) хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сургалтыг өөрийн ажилтнуудад зохион байгуулах үүргийг тээврийн үйл ажиллагаа эрхлэгчдэд хүлээлгэх зохицуулалтыг шинээр оруулж, зөрчигдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэж болохоор тусгажээ.²²

Хохирогч хүүхдийн хувьд нас нь тодорхойгүй байсны улмаас насанд хүрсэн гэж шууд тооцох нь насанд хүрсэн этгээдийг хүүхэдтэй адилтган үзэж тусламж үйлчилгээ үзүүлснээс илүүтэй хор уршиг, эрсдэл дагуулдаг болохыг анхаарах хэрэгтэй. Иймд хохирогчийн насны талаар эргэлзээтэй нөхцөл байдал үүсвэл хүүхэд гэж урьдчилан тооцох шаардлагатай.²³

Хохирогчийг зөв таньж тогтоосны дараа түүнийг хамгаалах арга хэмжээ эхэлнэ. Хохирогч хамгааллын тухай авч үзэхэд зөвхөн бие

¹⁹ UNDP, Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 100. <https://www.icmpd.org/file/download/54287/file/Law%2520Enforcement%2520Manual%2520to%2520Combat%2520Trafficking%2520in%2520Human%2520Beings.pdf>

²⁰ Өмнө дурдсан эх сурвалжид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нийтлэг шинж, насанд хүрээгүй хохирогчийн шинж, бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагдсан хохирогчийн шинж, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагдсан хохирогчийг тодорхойлох шинж, гэрийн үйлчлэгч, зарц, боолын зорилгоор худалдаалагдсан хохирогчийг тодорхойлох шинж зэргийг нэрлэн заагаад ямар байгууллага, албан тушаалтан, иргэн тэдгээртэй хамгийн эхэнд харилцах боломжтойг тодорхойлсон байна. Мөн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан гарын авлагад 1) хохирогчийг таньж тогтоох ерөнхий шинж, насанд хүрээгүй хохирогчийг таних шинж, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байгаа хохирогчийг таних шинж, 2) хохирогч байж болзошгүй хүнтэй ярилцлага хийх аргачлал, 3) хохирогчийг тогтоох шалгах хуудас (checklist), 4) эмнэлгийн ажилтан, хууль сахиулагчид зориулсан зааварчилгаа, ярилцлага хийх, мэдүүлэг авахад анхаарах ёс зүйн санамж зэрэг жишиг болохуйц эх сурвалжийг бэлдсэн байна

²¹ Тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага гэдэгт хүн, эд бараа, шуудан зэргийг хариу төлбөр болон бусад үр шим хүртэх зорилгоор тээвэрлэдэг этгээдийг ойлгоно. UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 20.

²² UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), Article 11.

²³ OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons (2022), page 74

махбодын хамгаалалтыг өрөөсгөл байдлаар төсөөлдөг. Хохирогч нь зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийн эсрэг гэрчийн мэдүүлэг өгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа бол энэ төрлийн хамгаалалт яригдах нь зүйн хэрэг. Гэхдээ хохирогчийн онцлогийг харгалзан үзэж дор дурдсан гурван төрлийн хамгаалалт шаардлагатай гэж үздэг.²⁴

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

Бие махбодын
хамгаалалт

Сэтгэл зүйн
хамгаалалт

Зүй бус
харьцахаас
хамгаалах

Бие махбодын аюулгүй байдлаас гадна хохирогчийн **сэтгэл зүйн “аюулгүй” буюу хамгаалалт** тун чухал байдаг.²⁵ Сэтгэл санаа нь тогтворжихоос өмнө ямар нэг байдлаар таагүй дүр зургийг нь дахин сануулж, дарамт шахалтад оруулах, айлгах, ичээхээс зайлсхийх, эсхүл сэтгэл санааны дарамтад оруулж дахин хохирогч болгохоос урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлууд энд багтана. **Зүй бусаар харьцахаас хамгаалах** асуудлын хувьд хохирогчийн эрхийг бүрэн дүүрэн эдлүүлж, нэр төрийг нь хүндэтгэн харилцах зэрэг багтдаг байна.

2.2.1. Хохирогчийн бие махбодын аюулгүй байдал

Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн бие махбодын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүргийг гишүүн улсуудад хүлээлгэжээ. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын чиглэлээр авах арга хэмжээ нь гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээтэй зарчмын хувьд адил байна. Тодруулбал, НҮБ-аас гаргасан Загвар хуульд хохирогчийн аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тухайн улсад хүчин төгөлдөр байгаа хамгаалалтын арга хэмжээнд хамрагдах боломжтой байх талаар заасан²⁶ ба энэ төрлийн арга хэмжээ нь биечилсэн хамгаалалт тогтоох, байрлал нь нууц байдаг хамгаалах байранд байршуулах, өөр газарт шилжүүлэх, овог, нэрийг өөрчлөх зэрэг хэлбэртэй байж болохыг заажээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүл, ойр тойрны хүмүүс нь байнгын эрсдэл дор байдаг онцлогтой. Иймд

²⁴ OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004), page 99.

²⁵ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 304-дэх тал.

²⁶ UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), Article 11, page 64.

хууль сахиулах, мөрдөх байгууллагынхны хувьд хохирогчийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах нь юу юунаас илүү чухал зорилт юм.²⁷ Гэхдээ үүнд чиглэсэн арга хэмжээ нь өөрөө зардал өндөр, хүн хүч, нөөц бололцоо ихээр шаарддаг тул тохиолдол нэг бүр дээр хэрэглэгдээд байдаггүй бөгөөд гол төлөв зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг илчлэх, илрүүлэхэд тус болохуйц мэдүүлэг өгөх хохирогчийг хамгаалалтад авах шаардлага гардаг.²⁸ Иймд хохирогчид аюулгүй байдлын ямар эрсдэл тулгараад байгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон шүүхийн шатанд тасралтгүй үнэлж дүгнэх нь мөрдөх байгууллагын үүрэг байна.²⁹ Эрсдэлийн үнэлгээ хийхдээ дараах хүчин зүйлсийг анхаарах хэрэгтэй:³⁰

- Хүн худалдаалах гэмт хэргийн нийтлэг эрсдэл - гүйцэтгэх ажлын болон цугларсан нотлох баримтад тулгуурласан, айлган сүрдүүлэх, өшөө авах арга барил хэр байдаг зэрэг мэдээллийг тусгасан.
- Хохирогчтой холбоотой эрсдэл – эмзэг байдал, нас, гэр бүл, аюулгүй байдлын зааварчилгааг даган мөрдөх чадвартай байдал гэх мэт.
- Сэжигтэн, яллагдагчийн зүгээс үзүүлэх эрсдэл - зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл, тэдгээрийн чадавх, гишүүдийн тоо, айлган сүрдүүлэх, өш хонзон авч болзошгүй талаарх гүйцэтгэх ажлын мэдээлэл, эсхүл нотлох баримт.
- Дээрх хоёр хүчин зүйлсээс улбаатайгаар бусад этгээдэд учирч болох эрсдэл. Жишээ нь хамгаалах байранд байгаа бусад хүн, эсхүл гэр бүлийн гишүүд гэх мэт.

Бие махбодын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь хохирогчийн онцлогтой нийцсэн дараах төрөлтэй байж болно:³¹

- Гэрчийн мэдүүлэг өгөх гэж байгаа хохирогчийг орон байрнаас нь шүүхийн байр руу хамгаалан хүргэх;
- Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимд аюулгүй байдлыг нь хангах, шүүх хуралдааны танхимд нэвтэрч байгаа оролцогчдын галт зэвсэг, бусад зэвсэг, зэвсгийн чанартай зүйл байгаа эсэхийг шалгах
- Хохирогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээллийг тухай бүр өгөх. Тухайлбал, яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээнээс сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгнө.

²⁷ UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 194.

²⁸ OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004), page 99.

²⁹ UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 194.

³⁰ Мөн тэнд, 198.

³¹ OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004), page 100.

Хохирогчийн бие махбодын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний дотор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, ялангуяа шүүх хуралдааны аюулгүй байдлын тухай асуудал зайлшгүй хөндөгддөг. НҮБ-ын Загвар хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хаалттай явагдахаас гадна хохирогчийн мэдүүлгийг шүүх хуралдааны танхимаас өөр газраас дуу-дүрсний төхөөрөмж ашиглан сонсох, хохирогчийн нэрийг нууцалж, зохиомол нэр ашиглах талаар дурджээ.³² НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас гаргасан гарын авлагад хохирогч нь мөрдөн шалгах ажиллагаанд төдийгүй шүүхийн шатанд дахин хохирогч болох магадлалтай байдал тул сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ёстойг дурдаад уг дэмжлэг нь дараах хэлбэртэй байж болохыг нэрлэн заажээ.³³

- Шүүх хуралдаан хэрхэн явагдах талаар мэдээлэл өгөх;
- Сэтгэл зүйчийг шүүхийн танхимд хамт байлгах;
- Эмзэг хохирогчтой харилцах талаар мэдлэгтэй, туршлагатай шүүгч, прокурор, цагдаа нарыг ажиллуулах;
- Шүүх хуралдааныг, эсхүл гарах шийдвэрийг хүлээх үед шүүгдэгчээс тусад нь байлгах тохитой өрөө тасалгаа бэлтгэх.

Түүнчлэн НҮБ-аас гаргасан гарын авлагад хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр прокурор дараах чиг үүрэгтэй байхаар тусгажээ.³⁴

- Гэрч-хохирогчийг таниулах мэдээллийг нууцлах;
- Хэрэгтэй танилцаж, гэрч-хохирогчийн мэдээллийг нууцлах шаардлага байгаа эсэхийг нягтлах;
- Гэрч-хохирогчийн аюулгүй байдалд заналхийлж болзошгүй байгаа тохиолдолд яллагдагчийг цагдан хорих, эсхүл санал гаргах;
- Хамгаалах байранд байрлаж байгаа гэрч-хохирогчтой аль болох уулзахгүй байх, шаардлагатай тохиолдолд нууц байдалд уулзах;
- Шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлын зураглалыг харгалзан үзэх. Шаардлагатай тохиолдолд хуралдааныг өөр байранд хийх санал гаргах;
- Шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлыг хангах талаар дараах арга хэмжээ авах:
 - Шүүхийн байранд урьдчилан очиж, аюулгүй байдлыг хангах боломжтой эсэхийг нягтлах;

³² UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 66.

³³ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 228 дахь тал.

³⁴ Мөн тэнд 226 дахь тал.

- Аудио болон видео холболтоор шүүх хуралдаанд өөр танхимаас оролцох боломжтой эсэхийг нягтлах;
- Гэрч-хохилогчийг яллагдагчид харагдахааргүй байлгах, өөр өрөө тасалгаанд байрлуулах;
- Шүүхийн захиргааны ажилтнуудад шаардлагатай мэдээллийг өгөх;
- Шүүхийн байр руу орох болон гарах гарцын аюулгүй байдлыг нягтлах;
- Шүүхийн байр, шүүх хуралдааны процессын талаар гэрч-хохилогчид урьдчилан тайлбарлах.

Хохирогчийн бие махбодын хамгаалалтын арга хэмжээнд хамгаалах байр чухал үүрэг гүйцэтгэнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхдийн аль нь ч байж болох тул тэдний онцлогт нийцүүлэн хамгаалах байрыг байгуулах ёстой.³⁵ Бусад хамгаалалтын арга хэмжээний адил хамгаалах байрны үйлчилгээ нь сайн дурын үндсэн дээр, уян хатан байх нь зүйтэй. Хамгаалах байрыг байгуулахад аюулгүй байдал, хоол хүнс, хувцас, багахан хэмжээний номын сан, гар урлал, биеийн тамирын үйл ажиллагаа, нийгмийн харилцаанд оролцох боломжтой байдлыг бүрдүүлэх хэрэгтэй.³⁶ Түүнчлэн бүх насны хүүхдийг эдгээр хамгаалах байранд уриалгахан угтан авч харьцах ёстой. Хүүхэд өөрт нь тухтай шинэ орчинд дасан зохицож эхэлснээр зан авир, сэтгэл хөдлөл, эрүүл мэнд, өөрийгөө арчлах байдал зэрэгт дордсон өөрчлөлт гарах магадлал байдаг бөгөөд энэ нөхцөл байдлыг туулж өнгөрүүлсэн таагүй үйл явдал, эмзэг байдалтай нь холбож ойлгох нь зүйтэй.³⁷

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас гаргасан гарын авлагад дурдсанаар түр зөвлөн туслах төв, нууц хамгаалах байр гэсэн хамгаалах байрны хоёр загвар байна. Нэгд, “Түр төв” буюу хохирогч нэн шаардлагатай үед очиж зөвлөгөө авах, төвийн зүгээс хохирогчийн эрсдэлийг үнэлж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны хамгаалах байрны үйлчилгээнд хамруулах зэрэг үйлчилгээг үзүүлнэ. Хоёрт, “Нууц хамгаалах байр” буюу аюулгүй байдлыг хангасан, овог нэр, хаяг зэрэг хувийн мэдээллийг нь нууцалсан байранд байлгадаг. Ийм төрлийн байрыг гол төлөв төвлөрсөн бус хэлбэрээр хийх нь аюулгүй байдлын талаас оновчтой байдаг бөгөөд түрээсийн орон сууцыг ашиглаж, тогтмол “хөдөлгөөнтэй” байлгах нь нэг том төвлөрсөн төв байлгахгаас давуу талтай байдаг байна.³⁸ Мөн хамгаалах байранд шинээр хохирогч хүлээн авах, гаргах

³⁵ UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 73.

³⁶ Мөн тэнд 74.

³⁷ Green, E. J. & Myrick, A. C. (2014), Treating complex Trauma in Adolescents: A Phase-Based, Integrative Approach for Play Therapists, International Journal of Play Therapy, 23(3), page 131-145.

³⁸ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 377 дахь тал.

журам, албан хаагчдын дотоод зохицуулалт, хамгаалах байртай холбоотой гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журам зэрэг зохицуулалтыг бүрдүүлэх хэрэгтэй.

Хохирогчийн бие махбодын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь хэдийгээр түүний болон ойр тойрны хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд тун чухал боловч энэ төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ заавал хохирогчтой зөвшилцөж, зөвшөөрлийг нь авах шаардлагатай. Энэ нь хүний эрхэд суурилсан хохирогч хамгааллын механизмын үндсэн суурь юм. Хамгааллын арга хэмжээг авахдаа сайтар ойлгуулж, шийдвэр гаргах нь хохирогч өөрийг нь тал бүрээс нь хянаж, сэтгэл зүйн хувьд түгшүүртэй нөхцөл байдалд оруулахаас сэргийлдэг байна. Олон улсад гаргасан зарим гарын авлагад уг зөвшөөрөл нь бичгийн хэлбэртэй байх ёстой талаар ч дурджээ.³⁹

2.2.2. Хохирогчийн сэтгэл зүйн хамгаалалт

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хохирогчийг сэтгэл зүй, бие махбодын зовлон шаналалд гүн оруулдаг тул “шок”-ын байдлаас гараагүй байхад нь яаран сандран мэдүүлэг авах, хэргийг илрүүлэхээр улайрахгүй, анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй юм. Хохирогч туулж өнгөрүүлснээ эргэн санах бүрд сэтгэцийн гэмтэл нь сэдэрэх эрсдэл өндөр байдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахдаа энэ байдлыг харгалзан үзэх ёстой.⁴⁰ Иймд энэ төрлийн арга хэмжээ нь хохирогч хамгааллын нэг хэсэг төдийгүй хамгийн үр дүнтэй арга хэрэгслийн нэгд тооцогддог байна.⁴¹ Сэтгэл зүйн гутрал, дарамт, шархнаасаа болж мөрдөх, яллах байгууллагатай хамтран ажиллахгүй байх, дайсагнасан, эсэргүүцсэн байдал гаргах, үйл явдлыг санахгүй байх, эсхүл болсон үйл явдлыг айдсаасаа болж зохиох зэрэг үйлдэл гаргаж болно.⁴²

Ийм учир НҮБ-аас гаргасан гарын авлагад хохирогчийн сэтгэл зүйн байдлаас хамаарч дараах арга хэмжээг авахыг зөвлөж өгсөн байна:⁴³

- Хохирогчийг гэмтэтгээдүүд болон тэдгээрийг санагдуулахуйц орчноос холтгох, аюулгүй мэдрэмж төрүүлэхүйц газарт хүргэх, байрлуулах;
- Яарч мэдүүлэг авах шаардлагагүй. Учир нь эхэн үед мэдүүлэг авах нь хохирогчийн болж өнгөрснийг санах, түүнийг даван туулах боломжийг хязгаарладаг бөгөөд мэдүүлэгт нь зөрүүтэй байдал үүсэх эрсдэлтэй байдаг;
- Хохирогчоос үнэн зөв мэдүүлэг авахын тулд сэтгэл зүйн байдал нь тогтворжтол хүлээх хэрэгтэй;

³⁹ UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 194.

⁴⁰ OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004), page 100.

⁴¹ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 304 дэх тал.

⁴² UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006), page 109.

⁴³ UNODC and UN.GIFT, Anti-Human Trafficking Manual for Criminal Justice Practitioners (New York:2009), page 11. https://www.unodc.org/documents/human-trafficking/TIP_module3_Ebook.pdf

- Ийнхүү тогтворжуулах явцад эмнэлгийн ажилтан (биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн талаас үнэлгээ өгөх), сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэх хэрэгтэй;
- Хохирогчоос мэдүүлэг авахдаа аюулгүй, тухтай орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Эхний мэдүүлэг нь зөвхөн болж өнгөрснийг ерөнхийлөн санагдуулах хэмжээнд байх хэрэгтэй бөгөөд ямар нэг тодруулсан асуулт тавих хэрэггүй. Мөн энэ үед хохирогч өөрт нь ямар нэг байдлаар халдаж болзошгүй байгаа тухай эсхүл тавгүй байгаа хүчин зүйлсээ хэлж болно.

Түүнчлэн хохирогчийн сэтгэл зүйн хамгаалалтын хүрээнд шаардлагатай мэдээ мэдээллээр урьдчилан хангах арга хэмжээг авах ёстой.⁴⁴ Нэмэлт протоколын 6 дугаар зүйлд хохирогчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээллээр хангах, уг ажиллагаанд шүүгдэгчийн эсрэг байр сууриа илэрхийлэх боломжоор хангах, өөрийнх нь мэддэг хэл дээр зөвлөх, туслах, эрхийг нь танилцуулах нөхцөлөөр хангах үүргийг гишүүн улсуудад хүлээлгэсэн. Энэхүү ажиллагаа нь заавал хохирогчоор тогтоосон шийдвэр гарснаар бус, харин эрх бүхий байгууллага, албан тушаалтан анх удаа харилцах үед явагдах ёстой гэж НҮБ-аас гаргасан Загвар хуульд тусгажээ.⁴⁵ Эдгээр арга хэмжээнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, хохирогчид туслалцаа үзүүлдэг чиг үүрэгтэй бусад байгууллагын зүгээс үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээ;
- Шүүхийн болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, хохирогчийн хувиар оролцохтой холбоотой асуудлууд;
- Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломж;
- Гэрч-хохирогчийг хамгаалах арга хэмжээ;
- Хувийн нууцаа хамгаалуулах эрх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл авах эрх;
- Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх хууль зүйн механизм, боломжийн талаар;
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн байгаа тохиолдолд түр оршин суух, орогнол хүсэх, бусад нөхцөл байдлын талаар.

Хохирогчийн сэтгэл зүйн хамгаалалтын үйл ажиллагаа тасралтгүй явагдах бөгөөд шүүх хуралдааны явцад ч энэ нь тун чухал ач холбогдолтой. Дуу болон дүрсээр холбогдох

⁴⁴ OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004), page 100.

⁴⁵ UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 60.

зэрэг технологи ашиглах, шүүх хуралдааныг хаалттай явуулах, шүүгдэгчийг танхимаас гаргах, шүүх хуралдааны орчны зохистой уур амьсгалыг бүрдүүлэх болон бусад арга хэмжээг ашиглан хохирогч сэтгэл зүйн хувьд таагүй мэдрэмж дахин авах, сэтгэл санаа нь түгших явдлыг багасгаж болно.⁴⁶

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой харьцаж ажилладаг хууль сахиулах байгууллагын алба хаагч болон бусад этгээдийн хувьд хохирогчид учирсан сэтгэцийн гэмтлийг харгалзан үзэх арга барилыг ашиглах нь зүйтэй. Хууран мэхлэлт, хүчирхийлэл, урвалт зэргийг удаа дараа амссан хохирогчийн хувьд итгэл даах хүнийг хайж олоход тун хүнд байдаг. Иймд энэ хандлага нь салбар бүрийн алба хаагчдыг хохирогчтой итгэл төрүүлсэн байдлаар харилцах, тайван, аюулгүй мэдрэмжийг төрүүлэх, итгэлийг нь бэхжүүлэх, таагүй үйл явдлыг дахин санах, сэтгэл санаагаар дахин хохирч үлдэхээс сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид аюулгүй, тайван байлгахад дөхөм болдог.⁴⁷

2.2.3. Хохирогчтой зүй бусаар харьцахаас хамгаалах нь

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын үндсэн тулгуур нь хохирогчийн эрх юм.⁴⁸ Гэвч хууль сахиулах байгууллагын албан хаагчдын зүгээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь тун онцлог бүхий эмзэг бие хүн гэдгийг эс хайхарч гэмт хэргийг илрүүлэх арга хэрэгсэл гэж үзэх нь бий. Хохирогчийг ийнхүү үзэх нь эргээд түүнтэй зүй бусаар харьцах эхлэл болдог байна. Мөрдөн шалгах, яллах байгууллагын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн мэдүүлэг ямар ч үнэ цэнтэй байгаагаас үл хамаараад түүнд эрхийг нь эдлүүлж зүй зохистой харьцах шаардлага гарцаагүй юм.

Хохирогчийг олон удаа, олон цагаар мэдүүлэг авах, олон хэлтэс, тасагт дуудах зэргээр залхаан цээрлүүлэх явдал гарч болно. Иймд хохирогчтой харилцахдаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар хангалттай хэмжээнд мэдээлэл өгөх, айлгаж эмээлгэсэн асуулт тавихгүй байх зэргээр наад захын стандартыг хэрэгжүүлбэл зохино.⁴⁹

Мөн хохирогчийн биед өөрийнх нь хүсэл зоригоос гадуур төрөл бүрийн шинжилгээ хийж болно. Зарчмын хувьд хохирогчид үзүүлж буй аливаа тусламж, үйлчилгээ, ялангуяа эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь үнэ төлбөргүй, сайн дурын, мэдээлэлд үндэслэсэн байхаас гадна хохирогчийн төрөл бүрийн эрэлт хэрэгцээг харгалзсан байна.⁵⁰

⁴⁶ "Special Protection Measures" of National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons (2022), page 224-226.

⁴⁷ OSCE, National Referral Mechanisms: Joining Efforts to Protect the Rights of Trafficked Persons (2022), page 75.

⁴⁸ UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking (2008) Principles: Article 1.

⁴⁹ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 290 дэх тал.

⁵⁰ UNODC, Model Legislative Provisions (Vienna: 2020), page 61.

Цаашлаад хохирогч нь биеэ үнэлэх, мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдаалах, эзэмших, хуурамч бичиг баримт эзэмших зэрэг гэмт хэргийг албадлага, шахалт, сүрдүүлгийн дор үйлдэж, эрүүгийн хариуцлагад татагддаг. Ийм нөхцөл байдлыг харгалзан шударга ёсыг хангах, хохирогч нь ял шийтгэлээс эмээлгүйгээр гэмт хэргийн талаар мэдээлэх, мөн сэтгэл санаагаар дахин хохирох явдлаас сэргийлэх үүднээс **эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг** байна.⁵¹

Энэ зарчмыг НҮБ-ын Хүн худалдаалахын эсрэг загвар хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийн загвар заалтын аль алинд тусгаж өгсөн. Мөн уг зарчим нь зөвхөн хууль тогтоомжид тусгагдсан байх нь хангалтгүй бөгөөд хууль тогтоомж, үйл ажиллагаа, бодлогын арга хэмжээний түвшинд огтлолцож байж сая хэрэгжихийг онцолсон байна. Уг заалтын тайлбарт үндэсний хууль тогтоомжид энэхүү зарчмыг тусгахдаа 1) зарчмын хэмжээнд⁵², 2) хуулийн тодорхой заалт хэлбэрээр⁵³, 3) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсны улмаас өөр гэмт хэрэгт шийтгүүлсэн бол энэ тухай мэдээллийг устгуулах хэлбэрийн аль нэгийг улс орнууд хуульчилж байгааг дурджээ. Түүнчлэн зарим улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн статустай байх явцад нь үйлдэгдсэн зөрчил, хэргээс шууд чөлөөлдөг бол зарим улсад бусдын эрхшээлд байсны улмаас гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцдог. Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцдог зохицуулалттай бол түүнийг нотлох ажиллагаа нь бусад гэмт хэргээс ялгаатай байх ёстой.

2.3. Хохирогчийн нэр төрийг хамгаалах, хувийн нууцлалыг хадгалах

Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг авч байгаа аливаа арга хэмжээ нь хүний, ялангуяа хохирогчийн нэр төр, эрх, эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх ёсгүй.⁵⁴ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь олон талаар хохирч үлддэгийн нэг нь түүний нэр төрд халдах явдал юм. Хохирогч болсон дээр нь тохуурхах, буруутгах, эсхүл бусдад энэ талаар мэдээлэх, эрүүл мэндийн зэрэг хувийн нууц эмзэг мэдээллийг нь задруулах зэрэг нь хохирогчийн нэр төрд арилгах боломжгүй хар толбо үлдээнэ. Иймд хохирогчийн нэр төрийг хамгаалах арга хэмжээний **хамгийн чухал хэсэгт хувийн нууцлалыг хамгаалах арга хэмжээ** багтдаг.

Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хохирогчийн хувийн нууцыг хадгалах, түүнийг таних мэдээллийг нууцлах,

⁵¹ UNODC, Model Legislative Provisions (Vienna: 2020), page 46.

⁵² Загвар заалтын агуулга: “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тухайн гэмт хэрэгт татагдсан нөхцөл байдлынхаа улмаас хийсэн аливаа хууль бус үйлдэл, эс үйлдэхүйд нь холбогдуулж цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, яллаж болохгүй.” UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 45.

⁵³ Загвар заалтын агуулга: “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь тухайн гэмт хэрэгт татагдсан нөхцөл байдлынхаа шууд үр дагаврын улмаас хийсэн аливаа хууль бус үйлдэл, эс үйлдэхүйнхээ төлөө эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээхгүй.” Мөн тэнд.

⁵⁴ UNODC, Recommended Guidelines on Human Rights and Human Trafficking, Guideline 1.

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах үүргийг хүлээлгэсэн. Ийм орчин нөхцөлийг бүрдүүлэх нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, нэр төрийг хамгаалаад зогсохгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас дөлж зугтах аас сэргийлэх, улмаар гэмт хэргийг нүдээр үзэж харсны хувьд хэргийн бодит үнэнийг мэдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой байна.⁵⁵

Улс орнууд хохирогчийн хувийн мэдээллийг нууцлах арга хэмжээг олон талт байдлаар авч хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрээс дурдвал,⁵⁶

- “Нууцлалыг хадгалах үүрэг хүлээх” нь гэрч-хохирогчийн талаарх хувийн мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчид дэлгэхгүй байх. (уг мэдээлэл нь шүүх хуралдаанд тавигдана.)
- Шүүх хуралдаанд “нэрийг нь нууцалсан” гэрч-хохирогчийн мэдүүлэг авах журмыг хуульчлах. Энэ тохиолдолд ялагч болон шүүх гэрч-хохирогчийн мэдээллийг мэдэж байх ба шүүгдэгчид уг мэдээллийг хаалттай байлгах;
- Гэрч-хохирогчийн оршин суугаа, эсхүл байрлаж буй хаягийг хавтаст хэргээс гаргаж, нууцлах;
- Шүүх хуралдааны явцад гэрч-хохирогчийн дүрс, яриаг өөрчилж сонсгох;
- Гэрч-хохирогчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулахгүйгээр мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг, эсхүл урьдчилж өгсөн мэдүүлгээр нотлох баримтад тооцох.

Мөн хохирогчийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах, задруулах зэрэг нь түүнийг “давтан хохирогч” болгох үр дагаврыг дагуулдаг тул хохирогч өөрийн овог, нэр, хаяг, хэрэг үйлдэгдсэн байдал (дэлгэрэнгүй тоочих), сэжигтэн, яллагдагчтай ямар харилцаатай талаар илэрхийлэхээс халширдаг.

Иймд хохирогчийн хувийн мэдээллийг эрх бүхий байгууллагууд хоорондоо дамжуулахдаа заавал хохирогчийн зөвшөөрлийг авсан байх хэрэгтэй. Жишээ нь мөрдөн шалгах байгууллага хохирогчтой холбогдолтой мэдээллийг сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлдэг байгууллагад шилжүүлэхдээ түүний зөвшөөрлийг авсан байвал зохино.⁵⁷

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэргийн талаар болон хохирогчийн талаар мэдээлэх асуудал мөн хөндөгддөг. Хүн худалдаалах гэмт хэрэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн

⁵⁵ UNODCCP, Guide for Policy Makers, (New-York:1999), p.iii.

⁵⁶ OSCE, National Referral Mechanisms: A Joint Efforts to Protect the Rights of Trafficked Persons: A Practical Handbook (2022), page 100.

⁵⁷ UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 68.

анхаарлыг татдаг. Иймд хохирогчийн хувийн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч, түүний нэр төрд халдахаас сэргийлэх арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай.

Зарим улс шүүх хуралдаанд энэ төрлийн хохирогчийн гэрийн хаягийг зарладаггүй, зарим улсын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслээр хохирогчийн эмзэг мэдээллийг гаргахтай холбоотой ёс зүйн дүрэм (Жишээ нь Англи) гаргасан, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс түүнтэй харилцахгүй байхыг сэжигтэн, яллагдагч болон бусад холбогдох этгээдэд даалгах зэрэг механизмыг ашиглаж байна.⁵⁸

НҮБ-ын Загвар хуульд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаарх бүхий л мэдээллийг үндэсний хууль тогтоомжийн дагуу нууцлах, уг мэдээллийг эрх бүхий албан тушаалтан, байгууллага хооронд дамжуулах, ашиглахтай холбоотой тусгайлсан журам гаргаж мөрдүүлэх, эмнэлгийн байгууллага, сэтгэл зүйч, хууль зүйн болон бусад тусламж үйлчилгээний хүрээнд олж авсан бусад мэдээллийг нууцлах, хохирогчийн нэр, хаяг, бусад таних мэдээллийг нууцлах, уг мэдээллийг задруулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

2.4. Насанд хүрээгүй хохирогчийн онцлог

Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Гишүүн улс бүр энэ зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хохирогчийн, ялангуяа насанд хүрээгүй хүний нас, хүйс, тусгай хэрэгцээ зэргийг харгалзан үзэх ёстой” гэж үүрэг болгосон байдаг.

Учир нь насанд хүрээгүй этгээдийн хувьд түүний ашиг сонирхлыг эн тэргүүнд авч үзэх ба насыг нь тогтоох, насанд хүрээгүй хүнтэй ажиллах мэдлэг, чадвартай сэтгэл зүйч болон боловсрол, халамж үйлчилгээний албан хаагчдыг ажиллуулах, харж хандах хүнгүй тохиолдолд асран хамгаалагч тогтоож өгөх, шаардлагатай мэдээллийг асран хамгаалагчаар нь дамжуулж өгөх, мэдүүлэг авах зэрэг онцлог зохицуулалт бүрдүүлэх шаардлагатай юм.

Юуны өмнө хохирогчийн насыг тодорхойлох боломжгүй байгаа бол насыг тогтоох хүртэл аль болох насанд хүрээгүй хүн гэж үзэж харилцах хэрэгтэй. Мөн дараах ажиллагааг хийхэд анхаарах хэрэгтэй:

⁵⁸ UNODCCP, Guide for Policy Makers, (New-York:1999), p.23.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ
ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН
НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАМГААЛАХ ТАЛААРХ ОЛОН
УЛСЫН ТУРШЛАГА

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид асран хамгаалагчийг томилох хэрэгтэй. Асран хамгаалагч нь хүүхдийн дээд ашиг сонирхлын төлөө ажиллана. Асран хамгаалагч нь хүүхдийн төрсөн эцэг, эх байх шаардлагагүй бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд ямар нэг хэлбэрээр оролцоогүй байна.
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад болон шүүх хуралдааны явцад сэжигтэн, яллагдагчтай харилцахгүй байх арга хэмжээг авах хэрэгтэй.
- Хүүхэд дахин хохирогч болохоос сэргийлж, хамгаалах байранд байрлуулах хэрэгтэй. Хамгаалах байр нь хүүхдийн нас, тусгай хэрэгцээнд тохирсон, аюулгүй, тохиромжтой сууц байна. Хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн бол ийм шаардлага хангах эсэхийг нягтлах хэрэгтэй.
- Хүүхэдтэй ажиллаж сурсан мэргэжилтнүүдийг ажиллуулах хэрэгтэй.⁵⁹

Насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авахад анхаарах зүйлсийг UNICEF байгууллагаас зөвлөмж болгон гаргасан байна:⁶⁰

- Хүүхдийг хүн худалдаалах гэмт хэрэгт татан оролцуулсан тухай мэдсэн даруйд сэтгэл зүйн нөхцөл байдлыг нь харгалзан мэдүүлэг авах;
- мэдүүлэг авах үед хүүхдийг аюулгүй газарт байлгаж, бусад хүмүүс түүнд тусална гэсэн итгэл үнэмшил төрүүлэх хэрэгтэй.
- эмэгтэй хүүхэд, мөн бага насны хүүхдээс эмэгтэй албан хаагч мэдүүлэг авах ёстой. Өсвөр насанд хүрсэн хөвгүүдийн хувьд эрэгтэй албан хаагч мэдүүлэг авч болно.
- мэдүүлэг авах үед тухайн хүүхдийн итгэдэг хүн байлцах хэрэгтэй. Тухайн этгээд нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах үүрэгтэй бөгөөд асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, эсхүл багш, нийгмийн ажилтан байж болно.
- мэдүүлгийг албан бус шинжтэй орчин нөхцөлд чөлөөтэй байдлаар авах бөгөөд хүүхэдтэй ажиллаж сурсан албан хаагч уг ажиллагааг явуулбал зохино.
- хүүхэд өөрийн мэддэг хэл дээр мэдүүлэг өгөх хэрэгтэй. шаардлагатай тохиолдолд орчуулагч авч болох боловч орчуулгыг аль болох богино байх хэрэгтэй.

⁵⁹ НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай гарын авлага (Вена: 2008), 356 дахь тал.

⁶⁰ UNICEF Reference Guide on Protecting the Rights of Child Victims of Trafficking in Europe (2006), <https://www.refworld.org/docid/49997af7d.html>

- мэдүүлгийг авах төлөвлөгөө гаргахдаа хүүхдийн нас, оюуны хөгжил зэргийг анхаарах хэрэгтэй.
- хүүхдийн онцлог, гэр бүлийнх нь нөхцөл байдал зэргийг мөн харгалзан үзэх хэрэгтэй.
- мэдүүлэг авахдаа хүүхэд өөрөө сайн дураараа тодорхой үйл явдлыг дүрсэлж ярих боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Түүний дараа асуулт тодруулга авч болно.
- мэдүүлгийг эхлэхдээ аль болох нээлттэй асуулт тавих хэрэгтэй. Үүний дараа шууд, чиглүүлсэн зэрэг асуулт тавьж болно.

2.5.Бусад асуудал

Хүнхудалдаалахгэмтхэрэгньхилдамнанүйлдэгдсэнтөхиолдолд хохирогч этгээд нь тухайн улсад оршин суух зөвшөөрөлгүй, эсхүл зөвшөөрөгдсөн хугацаа хэтэрсний улмаас хууль ёсоор оршин суугаа статусгүй болсон байдаг. Энэ асуудлыг Нэмэлт протоколын 7 дугаар зүйлд заасан хохирогчийг өөрийн нутаг дэвсгэрт түр болон байнгын хугацаагаар үлдэхийг зөвшөөрөх талаар хууль тогтоомжийн болон бусад зохих арга хэмжээ авах талаар заажээ. НҮБ-аас гаргасан Загвар хуульд энэ хугацааг 90-ээс доошгүй хоног гэж заасан бөгөөд дэлхийн улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцооны онцлогт тохируулан үүнээс багагүй хугацаагаар тогтоож байна. Гэхдээ энэ хугацаа нь тухайн улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл биш бөгөөд Нэмэлт протоколын 8 дугаар зүйлд зааснаар хохирогч болон түүний гэр бүлийн гишүүнийг нутаг буцаах нь аюулгүй байдалд нь ноцтой эрсдэл учруулах, эсхүл гэмт хэрэгт яллагдан шийтгэгдэхээр байвал оршин суух урт хугацааны зөвшөөрөл, цагаачлал олгож болдог.

Мөн түүнчлэн хохирогчид чиглэсэн аюулгүй байдлын арга хэмжээг авахаас гадна түүнд нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудал чухалд тооцогдоно. Нэмэлт протоколын 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хүн худалдах гэмт хэргийн хохирогчийг бие махбод, сэтгэл санаа, нийгмийн хувьд сэргэхэд туслах арга хэмжээг төрийн бус байгууллагатай хамтранхэрэгжүүлэхүүргийгхүлээсэнбөгөөдэдгээртхамгаалах байранд оруулах, зөвлөх, мэдээлэл өгөх, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусалцаа үзүүлэх, эд материалын тусламж өгөх, хөдөлмөр эрхлэлтэд нь туслах, боловсрол, сургалтын үйл

ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зэрэг багтахыг дурджээ. НҮБ-ын Загвар хуульд энэ арга хэмжээнд 1) аюулгүй байдлыг хангасан, зохих ёсны байраар хангах, 2) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, 3) хохирогчийн хувийн нууцлалыг хангаж, мэддэг хэл дээр нь зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, 4) хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах, өөрт учирсан гэм хороо арилгуулахтай холбоотой мэдээллээр хангуулах, 5) хөдөлмөр эрхлэлтэд нь дэмжлэг үзүүлэх, боловсрол, сургалтын боломжоор хангуулах, 6) орчуулгын үйлчилгээ үзүүлэх гэж заасан байна. Мөн боломжтой тохиолдолд эдгээр үйлчилгээг хохирогчийн хамаарал бүхий этгээдэд үзүүлэх, тусламж, үйлчилгээг зөвхөн өөрийнх нь зөвшөөрлийн дагуу үзүүлэх талаар заажээ.⁶¹

⁶¹ UNODC, Model Legislation Provisions (Vienna: 2020), page 61.

3

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН НЭР ТӨР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГА

Энэ хэсэгт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр хийх харьцуулсан судалгаанд хамруулах улс орнууд, тэдгээрийн онцлог, хүн худалдаалахтай тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын талаар товч танилцуулна. Энэ хүрээнд 1) эрх зүйн системийн хувьд манайтай ойролцоо, 2) хүн худалдаалахтай тэмцэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр жишиг туршлага болохуйц, 3) манай улстай нийгэм, эдийн засгийн хувьд төстэй гэсэн гурван хүрээнд улс орнуудын туршлагыг авч үзнэ. Эдгээр улсыг сонгохдоо эрх зүйн тогтолцооны ижил төстэй байдал, хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ахиц дэвшил гаргасан байдал, хохирогч хамгааллын асуудлыг нарийвчлан тогтоосон зохицуулалт (хууль эсхүл журам зэрэг хэлбэртэй) байгаа эсэх зэрэг шалгууруудыг харгалзсан болно.

3.1. Испани

Испани улс нь НҮБ-ын конвенцын нэмэлт протоколыг 2002 онд соёрхон баталж, Хүн худалдаалахын эсрэг Европын зөвлөлийн конвенцод 2008 онд нэгдэн орсон. Хүн худалдаалах үйлдлийг 2010 оноос эхлэн гэмт хэрэгт тооцсон. 2011 оны 10 дугаар Хууль зүй, Дотоод хэрэг, Хөдөлмөр эрхлэлт ба цагаачлал, Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, тэгш байдлын яамд, Шүүх, прокурорын зөвлөл хамтран “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаарх протокол”-ыг 2011 онд батлан гаргасан. Уг протокол нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогч хамгааллын үйл ажиллагаанд оролцдог байгууллагуудын эрх, үүрэг, хамтын ажиллагааны уялдаа холбоог болон төрийн бус байгууллагын оролцоог тогтоох зорилготой.⁶²

⁶² Протоколтой доорх холбоосоор орж танилцана уу. <https://rm.coe.int/168070ac7e#:~:text=The%20actions%20conforming%20the%20object,in%20criminal%20proceedings%20against%20traffickers.>

Тус протоколд хохирогч хамгааллын үйл ажиллагааны ерөнхий зарчим, хүн худалдаалах гэмт хэргийг нэг мөр ойлгох, уг хэргийн хохирогчийг хууль сахиулах, хөдөлмөр эрхлэлт болон бусад субъект, хил, гаалийн хяналтын зүгээс илрүүлсэн тохиолдолд баримтлах журам, хохирогчийг таньж тогтоох ажиллагаа, аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, хохирогчийг мэдээллээр хангах, хамгаалалтын болон аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, шаардлагатай тусламж үйлчилгээнд холбох, эрүүгийн хэрэг үүсгэх, прокурорын хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль бусаар оршин суугч хохирогчид авах тусгайлсан арга хэмжээ, хохирогчийг хариуцлагаас чөлөөлөх, ажиллах зөвшөөрөл олгох, хохирогч сайн дурын үндсэн дээр нутаг буцах, насанд хүрээгүй хохирогчийн талаар авах тусгай арга хэмжээ, байгууллага хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа, хурал зэрэг хохирогч хамгааллын өргөн хүрээтэй асуудлуудыг нарийвчлан зохицуулсан байна.

АНУ-ын Төрийн департаментаас гаргадаг Хүн худалдаалах гэмт хэргийн 2022 оны тайлан мэдээнд тус улсыг 1 дүгээр шатлалд буюу хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үр дүнтэй хүчин чармайлт гаргадаг гэж үнэлсэн.

Тус улсын хувьд Зүүн Европ, Өмнөд болон Зүүн Азиас гадаадын иргэдийг хууль бусаар авч ирж, хөдөлмөрийн мөлжлөгт оруулах, Хойд Африкаас Европ руу чиглэсэн хүн худалдаалах гэмт хэргийн урсгал дамжин өнгөрдөг, Зүүн Европ, Өмнөд Америк, Төв Америк, Вьетнам, Доминиканы БНУ, Хятад, Нигер зэрэг улсаас бэлгийн мөлжлөгт хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалан авч ирдэг зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн гаралт өндөртэй.⁶³ Тус улс нь Монгол Улстай эрх зүйн тогтолцооны хувьд ижил төстэйн зэрэгцээ хохирогч хамгааллын үйл ажиллагааны журмыг нарийвчлан гаргаж, хэрэгжүүлж хэвшсэн тул энэхүү судалгаанд хамруулах үндэслэл болж байна.

Хохирогчийг таньж тогтоох

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй тохиолдлыг хууль сахиулах болон бусад албан хаагчид илрүүлсэн бол энэ тухай харьяа прокурор, шүүх, цагдаагийн байгууллагад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу мэдэгдэнэ.⁶⁴ Цагдаагийн байгууллагын албан хаагчийн хувьд илрүүлсэн даруйд прокурорт цахим арга хэрэгслээр, хөдөлмөр халамжийн ажилтан илрүүлсэн бол нэгжийн даргаар дамжуулж прокурорын байгууллагад, бусад байгууллагын албан хаагчдын хувьд цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

⁶³ The United States Department of State, Trafficking in Persons Report: Spain (2022), <https://www.state.gov/reports/2022-trafficking-in-persons-report/spain/>

⁶⁴ Протоколын V.A. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй этгээдийг илрүүлэх

Хохирогчийг таньж тогтоох ажиллагааг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бэлтгэгдсэн цагдаагийн албан хаагч явуулна. Хохирогчоор таньж тогтоох ажиллагаа явагдаж байх явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.

Хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийг хамгаалах

Эрсдэлийн талаар цагдаагийн албан хаагч үнэлгээ хийгээд эрсдэлтэй гэж үзвэл энэ тухай хохирогчид мэдэгдэж, аюулгүй байдлын арга хэмжээ авна. Хэрэв хохирогч хамгаалалтын арга хэмжээ авхуулахаас сайн дураар татгалзвал энэ тухай баримтжуулна.⁶⁵

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд хэргийг хариуцан шалгаж байгаа хүний утасны дугаарыг өгөх, өөрийгөө хамгаалах арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, тодорхой аюулгүй газарт байх, эсхүл өөр газарт нүүхийг зааварчлах, оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг даалгах болон эрсдэлт нөхцөл байдалд тохирсон бусад арга хэмжээг авна. Эдгээр хамгаалалтын арга хэмжээг прокурорын байгууллагаас тогтоож өгсөн нөхцөлийн дагуу явуулна.⁶⁶

Прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шуурхай авах, хохирогчид эрхийг нь ойлгогдохуйц байдлаар танилцуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэх, Эрүүгийн хэргийн гэрчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хохирогчийг хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй байна.⁶⁷

Хохирогчоос мэдүүлэг авахдаа хувийн нууцлалыг нь хадгалах ёстой бөгөөд хохирогчийн нас, хүйс, бусад хувийн нөхцөл байдалд нийцсэн байдлаар мэдүүлгийг авна. Мөн цагдаагийн байгууллага нь хохирогчид дараах мэдээллийг ойлгомжтой, тодорхой байдлаар өгнө:⁶⁸

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 109, 110 дахь хэсэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх
- Эрүүгийн хэрэг дэх гэрчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг авах боломж
- Хохирогчийн бэлгийн эрх чөлөөнд халдсан тохиолдолд Бэлгийн эрх чөлөөний эсрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх тухай хуульд заасан тохиолдолд эдлэх эрх;

⁶⁵ Протоколын VIII

⁶⁶ Протоколын VIII.2.

⁶⁷ Протоколын XI.A.

⁶⁸ Протоколын VII.1

- Хохирогчийн нөхцөл байдалд тохируулан авах хамгаалалтын арга хэмжээ
- Бусад тусламж үйлчилгээнд холбох асуудал

Насанд хүрээгүй хохирогч

Протоколд зааснаар аюулгүй байдлыг хангах бүхий л арга хэмжээг насанд хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хохирогчид авч болно.⁶⁹ Хохирогч хүүхдэд нэн даруй тусламж, хамгаалалт, үйлчилгээг үзүүлнэ. Бүхий л арга хэмжээ нь тэдний аюулгүй байдал, бие махбодын хувьд болон сэтгэл зүйн хувьд сэргэх, боловсролд нь чиглэх ёстой.⁷⁰

Цагдаагийн мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хянан шийдвэрлэх бусад ажиллагаа нь түүнийг дахин хохирогч болохоос бүх талаар сэргийлсэн байвал зохино. Мэдүүлгийг прокурорын хяналт дор нэн даруй авна.⁷¹

Хэргийг шалгах явцад шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг авах бөгөөд эдгээрт дараах зүйлс багтана:

- аливаа хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авах ёстой
- насанд хүрээгүй хүнд зориулагдсан байр, газарт эдгээр арга хэмжээг авна
- мэдүүлгийг насанд хүрээгүй хүнтэй ажиллаж сурсан мэргэжилтэн удирдан авна.
- аль болох цөөн удаа мэдүүлэг авна. Мэдүүлэг авах явцыг дуу-дүрс бичлэгт буулгасан байна.
- ямар ч арга хэмжээг авсан хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нь хамт байлцана.

⁶⁹ Протоколын VIII.3.

⁷⁰ Протоколын XIV.A.

⁷¹ Протоколын XIV.C.1.

⁷² Article 172 of the Civil Code of Spain.

⁷³ GRETA, Report Concerning the Implementation of the Council of Europe Convention on Actions against Trafficking in Human Beings by Spain, Second Evaluation Report (2018), page 46. <https://rm.coe.int/greta-2018-7-frg-esp-en/16808b51e0>.

Хохирогч хүүхдийн асрамжийн асуудлыг тус улсын Иргэний хуульд заасан. Эмзэг нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн асуудлыг прокурорын хүсэлтээр шүүх шийдвэрлэдэг.⁷² Хэрэв хүүхэд зовлон бэрхшээл амссан байгаа бол мэргэшсэн байгууллагад шууд шилжүүлнэ. Эдгээр байгууллага нь хохирогч хүүхдэд асрамж хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.⁷³

3.2. Тайвань

Тус улсын хувьд Зүүн Өмнөд Ази болон Хятадаас зуучлалаар гэр бүл болгох, өндөр цалинтай ажлын байраар хууран мэхэлж, охид эмэгтэйчүүдийг бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгт оруулдаг, аж үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг гаднын иргэдийн хувьд гэрээт ажлын байраа орхисон (хөдөлмөрийн хүнд нөхцөл, албадан хөдөлмөрлүүлэх зэрэг шалтгааны улмаас дунджаар 50,000 гаруй ажилтан ажлын байраа орхин зугтдаг) тохиолдолд оршин суух зөвшөөрлийг нь цуцалдаг тул хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох өндөр магадлалтай байдаг бөгөөд хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгддэг.

Тайваний Засгийн газраас Хүн худалдаалахаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2006 онд гарган хэрэгжүүлж, уг гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах үүрэг бүхий хороог 2007 онд байгуулсан. 2009 онд Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг батлан гаргаж мөрдүүлсэн. Уг хуулиар хүн худалдаалах гэмт хэргийн нэр томъёо, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааны журам, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг илрүүлэх, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, цагдаагийн байгууллагаас хохирогчийг таньж тогтоох, хохирогч, түүний төрөл, санданд авах хамгаалалтын арга хэмжээний төрөл, журам, хамгаалах байр, хууль бусаар оршин сууж байгаа хохирогчийн хувьд түр оршин суух зөвшөөрөл олгох журам, хохирогчид үзүүлэх дэмжлэг тусалцаа, хохирогчийг шүүх хуралдаанд оролцуулахтай холбоотой онцлог зохицуулалт, хохирогчид хариуцлага хүлээлгэхгүй байх зарчим, хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэргийг нарийвчлан тусгажээ.⁷⁴

Шүүх эрх мэдлийн байгууллага нь хохирогчийг таньж тогтоох, хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөх, яллах үйл ажиллагааны журам, эдгээртэй холбоотой ажиллагааг төлөвлөх, эрүүл мэндийн байгууллага нь хохирогчийн биеийн байдлыг үнэлэх, гэмтлийн зэргийг үнэлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага нь хохирогчид чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оршин суух зөвшөөрөлтэй хохирогчид ажиллах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх, эргийн хамгаалалтын алба нь хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлыг илрүүлэх, шилжүүлэх, хохирогчийг таньж тогтоох, аюулгүй байдлыг хамгаалах зэрэг үүргийг хүлээхээр хуулийн 5 дугаар зүйлд заажээ.

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

⁷⁴ Уг хуультай энэхүү холбоосоор нэвтэрч танилцана уу. <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>

АНУ-ын Төрийн департаментас гаргасан Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын тайланд сүүлийн 12 жил дараалан 1 дүгээр түвшинд үнэлэгдсэн. 2021 оны хувьд хохирогчийг таньж тогтоох арга ажиллагааг тууштай баримталсан, шүүмжлэлд өртөөд байсан загасчлалын салбарт хөдөлмөрийн хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх, улмаар хүн худалдаалахаас сэргийлэх талаар арга хэмжээ авч ажилласан байна.⁷⁵

Иймд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон жил ахиц дэвшил гаргасан, олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн хүн худалдаалахтай тэмцэх, хохирогч хамгаалах талаар бие даасан хуулийг баталж, хэрэгжүүлдэг зэрэг үндэслэлээр жишиг болохуйц сайн туршлага гэж үзэн судалгаанд хамруулж байна.

Хохирогчийг таньж тогтоох

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, хохирогчийг таньж олох тухайд тус хуулийн 9 дүгээр зүйлд “цагдаагийн албан хаагч, гадаадын иргэн харьяатын алба, хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн албан хаагчид, эрүүл мэндийн ажилтан, иргэний бүртгэлийн ажилтан, боловсролын ажилтан, аялал жуулчлалын салбарын ажилтан болон хохирогчтой харилцах боломжтой бусад албан хаагчид нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй гэж үзсэн тухай бүр цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.” гэж хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэж байж болзошгүйг мэдэх боломжтой олон талын этгээдэд албан ёсоор үүрэг хүлээлгэсэн байна. Мөн тус зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр, оршин суугаа хаяг, бусад таниулах мэдээллийг энэ үе шатнаас нууцалж байна.⁷⁶ Мөн хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл хүлээн авах шуурхай утсыг ажиллуулахаар тус хуульд заасан.⁷⁷ Хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүй тохиолдол нэг бүрд цагдаа, прокурор нь хохирогчийг таньж тогтоох ажиллагааг шуурхай хийх, шүүхийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй шинээр илэрсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар хэргийг прокурорт шилжүүлэх үүргийг мөн хүлээлгэжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй этгээдийн хувь хохирогчоор тогтоох ажиллагаа явагдах хүртэл түр саатуулах байранд байлгана. Таньж тогтоох ажиллагааны дүнд хохирогч болох нь тогтоогдвол мөн хуульд заасан хамгаалах байранд хүргэнэ.⁷⁸

⁷⁵ АНУ-ын Төрийн департамент, Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын тайлан (2022), Тайвань, <https://www.state.gov/reports/2022-trafficking-in-persons-report/taiwan/>

⁷⁶ Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл (Human Trafficking Prevention Act (2009)) <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>

⁷⁷ Мөн хуулийн 10 дугаар зүйл.

⁷⁸ Мөн хуулийн 15 дугаар зүйл.

Хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийг хамгаалах

Мөн хуулийн 26 дугаар зүйлд цагдаа, прокурор, шүүх нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангахад анхаарах бөгөөд хохирогчийг сэжигтэн, яллагдагчаас тусгаарлах арга хэмжээг авах үүрэгтэй гэж заажээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон хохирогч байж болзошгүй этгээдэд дараах төрлийн хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:⁷⁹

- Хувийн аюулгүй байдлыг хангах;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ;
- Орчуулга, хэлмэрчлэх;
- Хууль зүйн туслалцаа;
- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж;
- Санхүүгийн тусламж;
- Бусад шаардлагатай тусламж

Эрх бүхий байгууллага, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн байгууллага нь шат шатандаа хамгаалах байрыг байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон **хохирогч байж болзошгүй этгээдийг** байрлуулна.

Хохирогчид үзүүлж байгаа тусламж үйлчилгээний зардлыг тухайн гэмт хэргийг үйлдэгч этгээдэд хариуцуулах талаар тус хуулийн 18 дугаар зүйлд заажээ. Тодруулбал, эрх бүхий байгууллага, эсхүл хөдөлмөрийн асуудал эрхэлсэн шат шатны байгууллага нь гэм хор учруулагч этгээдээр төлүүлэх зардлын хэмжээ, хугацааг заасан шийдвэр гаргах ба дурдсан хугацаанд зардлыг төлж барагдуулаагүй бол шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгүүлэхээр хуульд тодорхой тусгажээ.⁸⁰

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь тухайн гэмт хэрэгтэй холбогдолтой мэдээ баримтын талаар прокурор, шүүхийн өмнө мэдүүлэг өгөх бол түүнийг Гэрчийг хамгаалах тухай хуулийн 4-14, 20, 21 дүгээр зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулна.

Түүнчлэн хохирогчийг мэдүүлэг өгөх үед аудио болон видео бичлэгийг ашиглаж болох⁸¹ ба хууль ёсны төлөөлөгч, эхнэр эсхүл нөхөр, төрлийн хүн, гэр бүлийн гишүүн, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг нь хамт байлцаж болно.⁸²

⁷⁹ Мөн хуулийн 17 дугаар зүйл.

⁸⁰ Мөн хуулийн 18 дугаар зүйл

⁸¹ Мөн хуулийн 25 дугаар зүйл

⁸² Мөн хуулийн 24 дүгээр зүйл.

Мөн хохирогч нь сэтгэл зүйн нөхцөл байдал, шүүх хуралдааны явцад бүрэн дүүрэн мэдүүлэг өгөх боломжгүй сэтгэл зүйн дарамтад байгаа, эсхүл шүүх хуралдаан болохын өмнө гадаад улсад зорчсон тохиолдолд түүний мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгийг нотлох баримтаар шинжлэн судалж үнэлж болно.⁸³

Хохирогчийн овог нэр, төрсөн огноо, оршин суугаа хаяг болон холбогдох бусад мэдээллийг албан үүргийн дагуу олж авсан аливаа этгээд нь хуульд зааснаас бусад тохиолдолд нууцлах үүргийг хугацаагүй хүлээнэ. Түүнчлэн төрийн байгууллага нь олон нийтэд нээлттэйгээр шийдвэр, баримт бичиг гаргахдаа энэхүү нууцалсан мэдээллийг задруулахыг хориглоно.⁸⁴

Мөн хохирогчтой урьдчилан зөвшөөрөл авсан, эсхүл хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд түүний нэр, таних мэдээллийг агуулсан сурталчилгааны материал, хэвлэл, радио, телевизийн нэвтрүүлэг, цахим мессеж, интернэтийн болон бусад хэвлэлийн мэдээ, сурвалжилга бэлтгэхийг хориглоно.⁸⁵

Хохирогч хүүхэд

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон хохирогч байж болзошгүй хүүхдийг Хүүхэд болон өсвөр насны хүнийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх тухай хуульд заасан хамгаалах байранд байрлуулж, хамгаалалтын арга хэмжээ авна. Хүүхдийн бэлгийн мөлжлөг гэдэг нь хүүхэд, эсхүл өсвөр насны хүнтэй мөнгө болон бусад үнэ бүхий зүйл солилцож бэлгийн харилцаанд орох, бусад адилтгах үйлдэл хийх, дүрс бичлэгт оролцуулах, уушны газарт тусгай үйлчилгээ үзүүлэх ажилд оролцуулах, биеэ үнэлэх, бүжигчин, хөгжөөгч зэргээр ажиллуулахыг ойлгоно.

Хохирогчийг олж илрүүлсний дараа прокурор, шүүхийн цагдаагийн алба хаагч нь 24 цагийн дотор орон нутгийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Эрх бүхий байгууллага нь сургууль, ажил эрхлэлт, амьдралд дасан зохицох байдал, хувийн аюулгүй байдал, ар гэрийн байдал зэргийг үнэлнэ.⁸⁶ Хохирогчийг аюулгүй газар байрлуулснаас хойш 72 цагийн дотор уг арга хэмжээг үргэлжлүүлэх эсэх үнэлгээг эрх бүхий байгууллага өөрөө хийнэ. Хэрэв үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл шүүх шийдвэрлэх бөгөөд эрх бүхий байгууллагаас шүүхэд тайлан хүргүүлнэ. Хэрэв шүүх сунгахаар шийдвэр гаргавал хүүхдийг асран хамгаалах байгууллага, асран

⁸³ Мөн хуулийн 27 дугаар зүйл.

⁸⁴ Мөн хуулийн 21 дүгээр зүйл.

⁸⁵ Мөн хуулийн 22 дугаар зүйл

⁸⁶ Article 15 of Child and Youth Sexual Exploitation Prevention Act (2018).

хамгаалагч гэр бүл болон эрүүл мэндийн болон боловсролын бусад байгууллагад 3 сар хүртэл хугацаагаар байрлуулна.⁸⁷ Гурав сар тусам тогтмол үнэлгээ хийх ба арга хэмжээг сунгахаар бол шүүх шийдвэрлэнэ.⁸⁸

3.3. Босни-Герцоговени

Зүүн Европын орнуудын хэмжээнд социалист систем нуран унасны дараа хүн худалдаалах гэмт хэрэг нийгэм, эдийн засаг, хүний эрхийн томоохон асуудал болж хувирсан. Энэ үед Босни-Герцоговенийн хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байв. 2008 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Хүн худалдаалахтай тэмцэх арга хэмжээний тухай Европын зөвлөлийн конвенцод нэгдэн орсон. Мөн НҮБ-ын конвенцын нэмэлт протоколыг баталсан. 2007 онд “Босни-Герцоговенийн харьяат иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд тэдгээрийг болон гэрчийг хамгаалах журам”-ыг Сайд нарын зөвлөлөөс батлан гаргасан. Уг журамд хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, нэр томъёо, үйл ажиллагааны үндсэн зарчим, хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэх, мэдээллийг дамжуулах, хохирогчийг таньж тогтоох, хамгаалах арга хэмжээ, хууль зүйн болон нийгмийн шинжтэй туслалцаа, хүүхэд хамгаалал, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх журам, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, байгууллагуудын хүлээх үүрэг, координаци, санхүүжилт зэрэг асуудлыг тусгажээ.

АНУ-ын Төрийн департаментаас гаргасан хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тайлан мэдээнд тус улсыг 2 дугаар шатлалд оруулжээ. Тус улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах талаар олон улсын гэрээ конвенцын шууд хэрэгжилтийг хангуулсан, хандивлагч улсуудын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар энэ талаарх нарийвчилсан дүрэм, журмыг боловсруулж гаргасан зэргийг харгалзан судалгаанд хамруулах юм. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон Босни Герцоговени улсын харьяат иргэнийг хамгаалах журмыг 2007 онд Сайд нарын зөвлөлөөс баталжээ.

Журмын 3 дугаар зүйлд хохирогч хамгааллын үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, үл ялгаварлан гадуурхах, хувийн нууцлалыг хадгалах, хүүхдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд хангах, **олон салбарын хамтын ажиллагаанд суурилах**, нууцлалыг хадгалах зэрэг зарчимд суурилсан байхаар заажээ.

⁸⁷ Мөн хуулийн 16 дугаар зүйл.

⁸⁸ Мөн хуулийн 21 дүгээр зүйл.

⁸⁹ The United States Department of State, Trafficking in Persons Report: Bosnia and Herzegovina, <https://www.state.gov/reports/2022-trafficking-in-persons-report/bosnia-and-herzegovina/>

Хохирогчийг таньж тогтоох

Хохирогчийг таньж тогтоох ажиллагааг олон салбарын хамтын ажиллагааны зарчмаар явуулна. Энэ хүрээнд бүхий л үе шатанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд олдсон мэдээллийг хоорондоо солилцож, уялдаа холбоотой ажиллан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн талаар тулгамдсан асуудлыг хамтаараа шийдвэрлэдэг.⁹⁰ Эрх бүхий байгууллага гэдэгт Мөрдөн шалгах алба, Аюулгүй байдлын яам, Прокурорын газар, шүүх зэрэг багтана. Мөн энэ чиглэлээр бүртгэгдсэн төрийн бус байгууллагууд хохирогчийг хамгаалах чиглэлээр ажилладаг.⁹¹

Хохирогчийг таньж тогтоох ажиллагаа нь мэдээллийг харьцуулах, задлан шинжлэх замаар хохирогч хамгааллын үйл ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг тогтоосноор эхэлдэг.⁹²

Хохирогчоор тогтоох үндэс нь хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд оролцдог байгууллагаас ирүүлсэн мэдээ, баримт болон түүнтэй хийсэн ярилцлагад тулгуурлана.⁹³ Хохирогчийг таньж тогтоох ажиллагааны явцад түүнээс мэдүүлэг өгөх эсэх, хамгаалалтын арга хэмжээнд хамрагдах эсэхийг тодруулж зөвшөөрлийг нь авна.⁹⁴

Хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийг хамгаалах арга хэмжээ

Хохирогчид авах хамгаалалтын арга хэмжээ нь түүний эрүүл мэндийн байдал, нас, хүйс, нийгмийн гарал болон бусад нөхцөл байдалд тохирсон, эрэлт хэрэгцээнд нь тулгуурласан байх зарчмыг баримталдаг.⁹⁵ Хохирогчид дараах төрлийн хамгаалалтын арга хэмжээ авдаг:⁹⁶

- бие махбодын хамгаалалт
- хувийн нууц болон таниулах мэдээллийг нууцлах
- хууль зүйн туслалцаа
- нийгмийн болон эрүүл мэндийн хамгаалал, тусламж
- хүүхдийг хамгаалах тусгай арга хэмжээ

Дээрх арга хэмжээнээс бие махбодын хамгаалалтын арга хэмжээг авч үзье. Протоколын 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хохирогч өөрөө болон түүний аюулгүй байдлыг хариуцсан этгээдийн зүгээс бие махбодод нь аюул занал учруулж байгаа талаар мэдээлэл өгсөн тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ авна. Хамгаалалтын арга хэмжээг үнэлэх, авах шийдвэрийг

⁹⁰ Мөн журмын 3.4

⁹¹ Мөн журмын 2.

⁹² Мөн журмын 7.1

⁹³ Мөн журмын 7.2

⁹⁴ Мөн журмын 7.3.

⁹⁵ Мөн журмын 9 дүгээр зүйл.

⁹⁶ Мөн журмын 8 дугаар зүйл

прокурор гаргана. Хохирогчийн аюулгүйн зэргийн үнэлгээг прокурор, цагдаа, нийгмийн хамгааллын алба хамтран үнэлнэ. Нийгмийн хамгааллын алба нь орон нутгийн цагдаагийн хэлтэстэй хамтран хохирогчийг аюулгүй байгаа эсэхэд хяналт тавих хугацааг болон хохирогчид нэн шаардлагатай мэдээлэл өгөх үйл ажиллагааг тодорхойлно.⁹⁷

Хүн худалдаалахтай холбоотой гомдол, мэдээллээр эрүүгийн хэрэг үүсгээгүй тохиолдолд тухайн хүнийг хохирогчоор тогтоох үндэслэл байсан эсэхээс үл хамаараад нийгмийн халамжийн байгууллага нь хохирогч хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан эсэхээс үл хамаараад хохирогчийн аюулгүй байдлыг хангана.⁹⁸

Хамгаалалтын арга хэмжээ авах журмыг мөн тогтоож өгсөн байна. Аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хамгаалалтын аливаа арга хэмжээг нийгмийн хамгааллын албанаас төлөвлөж зохион байгуулах бөгөөд хохирогчийн зөвшөөрөлд үндэслэсэн байна.⁹⁹ Насанд хүрээгүй этгээдийн хувьд хамгаалалтын арга хэмжээ, тусламж үйлчилгээг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр авна.

Хамгаалалтын арга хэмжээний талаар дараах байдлаар журамлан зохицуулсан байна:¹⁰⁰

- Прокурорын байгууллага, цагдаагийн алба нь хохирогчийн бие махбодын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бөгөөд хохирогчийн ойр орчны нөхцөл байдлыг судлан үзэж, шаардлагатай мэдээллийг цуглуулна. Энэ хүрээнд **өндөр эрсдэлтэй тохиолдлыг байршуулах хамгаалах байрыг байгуулсан** байна.
- Прокурорын байгууллага, цагдаагийн алба нь хохирогчид шүүхийн болон захиргааны журмаар явагдаж буй аливаа ажиллагааны талаарх мэдээллийг өгөх бөгөөд хохирогч гэмт этгээдийн холбогдсон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн байр суурийг илэрхийлэн оролцох боломжтой болно.
- Хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлын талаар мэдээлэл авсан даруйд нийгмийн хамгааллын алба нь тухайн хэрэг өмнө нь гарч байсан эсэхийг тодруулах, нэмэлт мэдээллийг цуглуулах, хэргийг үнэлэх, хохирогчтой холбоо тогтоох, ярилцлагад бэлтгэх, хийх, төрийн болон төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллаж хохирогчийн биед үүссэн гэмтэл бэртлийг үнэлэх, цаашид учирч болзошгүй гэмтэл

⁹⁷ Мөн журмын 10.5.

⁹⁸ Мөн журмын 10.7

⁹⁹ Мөн журмын 17.1.

¹⁰⁰ Мөн журмын 17.3.

бэртлийг тооцоолох, хохирогчтой зүй бусаар харьцсан байдлын талаар баримт сэлт бэхжүүлж авах, хамгаалалтын болон тусламж, үйлчилгээний нөөц бололцоог тогтоох, улмаар яаралтай авах арга хэмжээг тодорхойлох, хамгаалалтын арга хэмжээний төлөвлөгөөг бэлтгэх зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

- Хамгаалалтын арга хэмжээ авах хүрээнд хохирогч, гэрч-хохирогчийг хамгаалах байранд байрлуулах шаардлагатай тохиолдолд хангалттай тооны байрыг бэлэн байлгах, насанд хүрсэн хохирогчийг өөр гэр бүлд түр байрлуулах, насанд хүрээгүй хохирогчийг асран хамгаалах гэр бүлд түр байрлуулах, нийгэм, хүүхэд хамгааллын үйлчилгээний төвд байрлуулах зэрэг арга хэмжээг авна.
- Нийгмийн хамгааллын албанаас холбогдох эрх бүхий байгууллагаас хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт гаргаж болно.
- Хохирогчийг эргэн хэвийн амьдралд оруулах үүднээс сургалт, мэргэжлийн боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой арга хэмжээг нийгмийн хамгааллын албанаас авч хэрэгжүүлнэ.

Үйлчлүүлэгчийн хувийн нууц, үйл ажиллагааны нууцлалыг хадгалах нь үйл ажиллагааны мэргэжлийн стандарт болох, хүн худалдаалахтай тэмцэх, хохирогч хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй аливаа байгууллага албан тушаалтан хэрхэн олж авснаас үл хамааран мэдээллийн нууцлалыг хадгалах нь хүн худалдаалахтай тэмцэх ажлын гол зарчим болно.¹⁰¹

Хохирогч хүүхэд

Протоколд хүүхдийн дээдашиг сонирхлыг хангах явдлыг үндсэн зарчим болгон тогтоож өгсөн. Насанд хүрээгүй хохирогчтой холбоотой онцлог зохицуулалтууд мөн бий. Энэхүү зарчим нь эрх бүхий байгууллагын хувьд үүрэг байх бөгөөд хүүхдийг хурдан шуурхай хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн оруулж нөхөн сэргэх арга хэмжээг шууд хэрэгжүүлэх ёстой.¹⁰²

Аливаа хүүхэд нь эрх бүхий байгууллагад хандан өөрийгөө хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоолгох эрхтэй. Мөн гэмт хэргийн талаарх өргөдөл мэдээллийг тухайн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, хүүхдийн асрамж хамгаалал хариуцсан байгууллагаас гаргаж болно.¹⁰³ Нөгөө талаас эрх бүхий байгууллага нь хүүхэд аливаа хэлбэрийн хүчирхийлэл,

¹⁰¹ Журмын 3 дугаар зүйлийн (1) – (4)

¹⁰² Мөн журмын 15.1.

¹⁰³ Мөн журмын 4 (2)

¹⁰⁴ Мөн журмын 5 (3)

мөлжлөгт өртөн эрх нь зөрчигдсөнийг илрүүлсэн даруйдаа асран хамгаалж буй этгээдэд нь мэдэгдэнэ.¹⁰⁴

Гадаад харилцааны яам нь тус улсын харьяат иргэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсныг өөрийн шугамаар олж илрүүлсэн бол өөрийн улсын прокурорын газар, цагдаагийн албанд энэ талаар мэдэгдэж, гадаад улсын холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл цуглуулах үүрэгтэй байна.¹⁰⁵

Хэрэв хүн худалдаалах, мөлжлөгт оруулах үйлдлийг гэр бүлийн гишүүн нь хийсэн бол насанд хүрээгүй этгээдийг нэн даруй гэр бүлээс нь тусгаарлаж, асран хамгаалагч томилж өгнө.¹⁰⁶ Мөн энэ тохиолдолд эцэг, эх байх эрхийг хасах ажиллагааг эхлүүлэх бөгөөд хүүхдийг эцэг, эхийн өсгөн хүмүүжүүлэх үүргээс гадуур байгаад тооцно.

¹⁰⁵ Мөн журмын 7 (7)

¹⁰⁶ Мөн журмын 15.2.

4 | ДҮГНЭЛТ

САНАЛ

Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны төв хэсэгт хохирогчийн аюулгүй байдал байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь нууцлаг байдлаар үйлдэгддэг тул хэргийг нотлохуйц баримт мэдээллийн цор ганц эх үүсвэр нь хохирогч болох нь бий. Нөгөө талаар хохирогч нь бие махбод, сэтгэл зүйн хувьд асар их дарамтад өртөж, хохирсон байдаг бөгөөд энэхүү нөхцөл байдлыг үл хайхарч гэмт хэргийг нотлох арга хэрэгсэл гэж үзвэл энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа бүтэлгүйтэхээс гадна нууц далд хэлбэрт хэвээр үлдэж, ирээдүйн олон хохирогч үүсэхээс сэргийлнэ.

Энэхүү судалгаанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдал, нэр төрийг хүндэтгэн хамгаалах асуудлыг холбогдох олон улсын гэрээ конвенц, зөвлөмж, судалгаа, гарын авлага зэрэгт тусгасан жишиг туршлага, хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр тууштай ахиц гарган ажилладаг Испани, Тайвань, Босни-Герцоговени улсуудын туршлагад тулгуурлан судлав. Иймд уг судалгаа нь тодорхой асуудлыг судалж, шийдвэрлэх гэхээс илүүтэй лавлагааны шинжтэй болсныг тэмдэглэх хэрэгтэй.

Судалгаанд багтаасан мэдээлэл болон дэлгэрүүлэн судлах эх сурвалжийг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3-т заасан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмын төслийг боловсруулахдаа ашиглах боломжтой. Ийнхүү ашиглахдаа хохирогч хамгааллын үйл ажиллагаанд дөхөм болохуйц дараах саналыг ашиглах боломжтой:

1. Нэгдмэл, цогц байдал, олон талын оролцоо

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үйл ажиллагаа нэгдмэл, цогц шинжтэй олон салбарын огтлолцол дээр явагддаг үйл ажиллагаа болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Зөвхөн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг түлхүү авч хохирогчийн бие махбод, сэтгэл зүйн эмзэг байдлыг эс хайхарвал бүрэн үр дүнд хүрэхгүй бөгөөд эсрэгээрээ хохирогчийг хууль хяналтын байгууллагаас зугтах, зайлсхийх байдалд хүргэх, мөрдөн шалгах ажиллагааны дүнд нөлөөлөх эрсдэлтэй.

Юуны өмнө хүн худалдаалахтай тэмцэх үүрэг хүлээсэн субъектүүд чиг үүргийнхээ талаар нэг мөр ойлголттой, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны зарчмыг нарийвчилж гаргах хэрэгтэй. Түүнчлэн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг хуульд тусгах шаардлагатай.

Хохирогч хамгаалалтай холбоотой эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг, уг ажиллагаанд оролцох оролцооны талаарх Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим зохицуулалт тунхаглалын шинжтэй байгааг өөрчилж, үйл ажиллагаа, дэс дараалал, журам хэлбэртэй болгох шаардлагатай. Энэ хүрээнд хохирогчийг таньж тогтоох, тусламж, үйлчилгээнд холбон зуучлах, хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг одоогийн хуульд заасан үйл ажиллагаанд хууль сахиулах, хил хамгаалах, прокурор, боловсрол, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хэрхэн оролцох талаар журамласан зохицуулалт бий болгох хэрэгтэй. Түүнчлэн эдгээр байгууллага хооронд мэдээлэл, статистик, бусад шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй солилцож байх зарчмыг тогтоох нь зүйтэй. Ингэснээр хохирогч хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдана.

2. Арга барил, хандлага

Хүн худалдаалахтай тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хамгааллын чухал хэсэг нь хууль сахиулах болон бусад байгууллага, албан хаагчдын хандлага, арга барил юм.

Энэ чиглэлээр аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хохирогчийн эрх, нэр төрийг хүндэтгэн үзсэн байна. Хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, хохирогчид учирсан сэтгэцийн гэмтэл, эмгэг зэргийг харгалзан үзсэн хандлага нь гол суурь болно.

Энэ хүрээнд эдгээр хандлагыг алба хаагчдын түвшинд нэг мөр ойлгох, сургалтад заавал хамруулах зэрэг асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газраас хамтран батлах журамд тусгах боломжтой.

3. Хохирогчийг таньж тогтоох ажиллагаа

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг аль болох эрт таньж тогтоох нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний урьдач нөхцөл болдог. Гэсэн хэдий ч Монгол Улс хохирогчийг таньж тогтоох нэгдсэн аргачлалгүй, хууль сахиулах байгууллагаас өөр салбарын ажилтан албан хаагчид хохирогчтой тааралдсан ч таньж мэдэх, тогтоох мэдлэг, мэдээлэлгүй байгаа юм.

Иймд энэхүү судалгаанд заасан туршлагыг харгалзан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажиллаж болохуйц боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллагын зэрэг алба хаагчдын гүйцэтгэх үүргийг тусгасан нэгдсэн аргачлал гаргах шаардлагатай. Аргачлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас манлайлж, хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран боловсруулах нь зүйтэй.

Түүнчлэн эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх ажиллагаа нь тодорхой цаг хугацаа, баримт нотолгоо шаарддаг бөгөөд энэ хооронд хохирогч хамгааллын үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй тул “хохирогч байж болзошгүй” гэж таньж тогтоон хамгаалалтын арга хэмжээг авах шаардлагатай байдаг.

4. Хохирогчийг мэдээллээр хангах

Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулж хамгаалах үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг нь түүнд шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй, ойлгомжтой, тодорхой хэлбэрээр өгөх явдал юм. Гэвч хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчид мэдээлэл өгөхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй. Иймд шинээр боловсруулах журамд хохирогчид өгөх мэдээллийн жагсаалтыг тусгаж болох юм. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлдэг тусламж, үйлчилгээ
- Эрүүгийн болон захиргааны шинжтэй процессын үе шат, үйл явц
- Хууль зүйн үнэ төлбөргүй эсхүл бага хэмжээтэй туслалцаа авах боломж

- Хохирогчийг болон гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээ
- Хувийн нууцлалаа хангуулах эрх
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээлэл авах эрх
- Хохирол нөхөн төлүүлэх асуудал
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд оршин суух зөвшөөрөл, орогнол, оршин суух эрх хүсэхтэй холбоотой зохицуулалт

Мөн хохирогчид ойлгомжтой, тодорхой байдлаар шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг ойлгомжтой, тодорхой байдлаар өгөх үүргийг хууль сахиулах болон прокурорын байгууллагын алба хаагчдад хүлээлгэх нь зүйтэй.

5. Хамгаалалтын арга хэмжээ авах журам

Юуны өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, хохирогчоор албан ёсоор тогтоосон эсэхээс үл хамаарч хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон байж болзошгүй гэж үзсэн бол шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авах талаар журамд тусгах хэрэгтэй.

Мөн аливаа арга хэмжээг заавал хохирогчийн өгсөн зөвшөөрлийн дагуу явуулах талаар журамд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Учир нь хамгаалалтын ажиллагаа өөрөө албадлагын арга хэмжээ биш тул сайн дурын оролцоонд тулгуурлах хэрэгтэй.

Мөн хохирогчийн аюулгүй байдалд үүсэж болох эрсдэлийг тогтмол үнэлэх үүргийг тухайн хэргийг шалгаж буй мөрдөгч, прокурорт өгөх шаардлагатай. Ингэснээр хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг алдалгүй авах, хохирогчийн бодит нөхцөл байдлын талаар мөрдөгч, прокурор мэдээлэлтэй болох ач холбогдолтой.

Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ өөрөө зардал өндөртэй. Харин Тайваньд аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлдэг механизм байгаа бөгөөд үүнийг судалж нэвтрүүлэх боломжтой.

6. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа

Судалгаанд дурдсан зарим улс төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг цахимаар мэдээлэл солилцож, шийдвэр гаргах хувилбарыг нэвтрүүлэх боломжтой.

Ийм сувгийг ашиглан хохирогчийг таньж тогтоох, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтын арга хэмжээ авах ажиллагааг тасралтгүй явуулж, ажиллагааг хөнгөвчилж болно.

Үүний тулд цахим платформ хөгжүүлэх бөгөөд хохирогчийг таньж тогтоох, байгууллага хооронд шуурхай холбоо тогтоох, ажиллагааны бүртгэл-хяналт хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээ, хамгаалалтын арга хэмжээнд холбон зуучлах, тайлан мэдээлэл гаргах зэрэг функцийг эхний ээлжид хөгжүүлэх ёстой.

Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хоорондын харилцаа сайжрахаас гадна уялдаа холбоо нь хангагдах, нэгдсэн бүртгэл статистик хийх, улмаар шаардлагатай тусламж, үйлчилгээг нэг ч хохирогч үлдээлгүй жигд хүргэх нөхцөл бүрдэнэ.

7. Насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах

Хохирогч хамгааллын арга хэмжээ дотор насанд хүрээгүй хохирогчийн онцлогт тохирсон арга хэмжээ чухал ач холбогдолтой байна.

Эдгээрт аюулгүй байдлыг нэн даруй хангах, гэмт хэрэг үйлдэгчээс тусгаарлах (гэр бүлийн гишүүн нь уг гэмт хэрэгт оролцсон бол мөн адил тусгаарлах), нас, бие хөгжлийн онцлогт тохирсон хамгаалах байранд байрлуулах, мэдүүлгийг мэргэшсэн, адил хүйсийн ажилтнаар, аль болох тайван орчинд авхуулах, нас, гэр бүл зэрэг нөхцөл байдлыг нь харгалзан үзэх, өөрөө сайн дураар ярих боломжийг бүрдүүлэх, аль болох цөөн удаа мэдүүлэг авах, хамгийн итгэлтэй гэсэн хүнийг байлцуулах зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Түүнчлэн хохирогчийг насанд хүрсэн эсэхийг шууд тодорхойлох боломжгүй байгаа бол насанд хүрээгүй хүнтэй адилтган авч үзэж, албан ёсоор нас тодорхойлох хүртэл хамгаалалтын арга хэмжээ авах хэрэгтэй талаар олон улсын баримт бичгүүдэд зөвлөмж болгосныг журамд тусгах нь зүйтэй.

--oOo--

Ашигласан эх сурвалж

- АНУ-ын Төрийн департамент, Хүн худалдаалах гэмт хэргийн тайлан мэдээ (2021).
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын https://www.unodc.org/res/human-trafficking/2021the-protocol-tip_html/TIP.pdf.
- IOM, Guidelines for Assisting Victims of Human Trafficking in the East Africa Region (2011).
- IOM, Investigating Human Trafficking Cases Using a Victim-centred Approach: A Trainer's Manual on Combating Trafficking in Persons for Capacity-building of Law Enforcement Officers in Antigua and Barbuda, Belize, Jamaica, and Trinidad and Tobago (2018).
- NEXUS, Identifying Trafficking Victims: An Analysis of Victim Identification Tools and Resources in Asia (2020).
- OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004).
- OSCE, National Referral Mechanisms: A Joint Efforts to Protect the Rights of Trafficked Persons: A Practical Handbook (2022)
- UNODC, The Model Legislative Provisions against Trafficking in Persons, (Vienna: 2020).
- UN Office of the High Commissioner for Human Rights, Recommended Principles and Guidelines on Human Rights and Human Trafficking (2008).
- UNODC, Toolkit to Combat Trafficking in Persons: Global Programme against Trafficking in Human Beings (Vienna, 2008).
- OSCE, National Referral Mechanisms: A Practical Handbook (2004).
- The Group of Experts on Action against Trafficking in Human Beings (European Council), <https://www.coe.int/en/web/anti-human-trafficking/greta>

- UNDP, Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006).
- UNDP (ICMPD), Law Enforcement Manual to Combat Trafficking in Human Beings (2006).
- UNODC and UN.GIFT, Anti-Human Trafficking Manual for Criminal Justice Practitioners (2009), https://www.unodc.org/documents/human-trafficking/TIP_module3_Ebook.pdf
- UNODCCP, Guide for Policy Makers, (New-York:1999).
- UNICEF, Reference Guide on Protecting the Rights of Child Victims of Trafficking in Europe (2006). <https://www.refworld.org/docid/49997af7d.html>
- Human Trafficking Prevention Act of Taiwan (2009). <https://law.moj.gov.tw/ENG/LawClass/LawAll.aspx?pcode=D0080177>
- Uniform Guidelines for the Identification and Referral of Victims of Human Trafficking within the Migrant and Refugee Reception Framework in the OSCE Region.

Council of Ministers of Bosnia Herzegovina, the Rules on Protection of Victims and Victim-Witnesses of Trafficking in Human Beings Who are Citizens of Bosnia Herzegovina

